



 **GOLOMT BANK**

ANNUAL
REPORT

2017

АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

БИДНИЙ АЛСЫН ХАРАА, ЭРХЭМСЭГ ОРШИХУЙ, СТРАТЕГИ

Стратеги хэрэгжилт
Инноваци нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ
Харилцагч төвтэй бүтээгдэхүүн
Дижитал маркетинг, борлуулалт
Харилцагчийн боловсролд

ЖИЛИЙН
ТАЙЛАН

2017

ЭДИЙН ЗАСАГ, БАНКНЫ СЕКТОР

Эдийн засгийн орчин
Банкны сектор

ГОЛОМТ БАНКНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэдийн зах зээл
Байгууллагын зах зээл
Гадаад эх үүсвэр, хамтын ажиллагаа
Арилжаа, нөөцийн удирдлага

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүний нөөц

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Комплаенсийн эрсдэлийн удирдлага

АКТИВ, ПАССИВЫН УДИРДЛАГА

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ-ийн хороод
ТУЗ-ийн гишүүд
Банкны бүтэц, зохион байгуулалт
Дотоод аудит

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувь нийлүүлэгчид, харилцагчид, түнш байгууллагууд, хамтран ажиллагсад, хатагтай ноёдоо!

Голомт банкны хамт олны 2017 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны үр дүнгээс та бүхэнд тайлагнахаар мэндчилж байгаадаа баяртай байна.

2017 онд Монгол Улсын Засгийн газар, ОУВС-тай хамтран 434 сая ам.долларын санхүүжилт бүхий Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр болон төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлсэн. Мөн дэлхийн зах зээл дэх түүхий эдийн ханш, экспортын бараа бүтээгдэхүүний үнэ өссөн зэрэг хүчин зүйлсээс үүдэн Монгол Улсын эдийн засаг банк санхүүгийн салбарын хөгжил эргэн сэргэсэн жил тохиолоо.

2 Тус онд Монгол Улсын экспортын орлого 26 хувь өссөнөөр гадаад худалдааны тэнцэл түүхэн дээд хэмжээнд буюу 1,9 тэрбум ам.долларт хүрсэн юм. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт 2 дахин нэмэгдэж 1,25 тэрбум ам.долларт хүрсэн нь төсвийн алдагдал 2 дахин буурч, эдийн засгийн өсөлт 5.1 хувьтай гарахад нөлөөлөөд байна.

Эдийн засгийн эдгээр эерэг үзүүлэлт нь хөрөнгө оруулагчдын итгэлийг эргэн сэргээсэн учраас Засгийн газраас олон улсын зах зээлд 1,4 тэрбум ам.долларын урт хугацаат бондыг амжилттай гаргаад байна.

Олон улсын үнэлгээний байгууллагууд ч эдийн засгийн энэхүү өсөлтийг бататгаж, Мүүдис агентлаг 2018 оны 1-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В3 болгон өсгөж, Фитч агентлаг хандлагыг эерэг болгон дээшлүүлсэн юм.

ОУВС-аас Монголбанкинд тавьсан хүсэлтийн дагуу Европын Төв банкнаас боловсруулсан аргачлалд тулгуурласан активын чанарын үнэлгээг арилжааны банкуудад хийсэн нь монголын банкны салбарын ил тод байдлыг хангах, хөрөнгө оруулагчдыг татах, хууль эрх зүйн шинэчлэл хийх зэрэг шинэ боломжуудыг нээгээд байна.

Тус үнэлгээгээр банкуудын активын чанарын үнэлгээ 91 хувь буюу эдийн засагчдын урьдчилан таамаглаж байснаас өндөр үзүүлэлттэй гарсан. Тодруулбал, банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн дутагдал ДНБ-ний 1.9 хувь буюу ойролцоогоор 200 сая ам.доллартай тэнцэж байгаа нь арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар туйлын эерэг байгааг харуулж байгаа юм.

Эдийн засаг нөхцөл байдал сайжирсан тул Монголбанк мөнгөний бодлогын хүүг 14-өөс 11 хувь хүртэл бууруулаад байна. Энэ нь зээлийн хүү буурч, мөнгөний нийлүүлэлт өсөх урьдач нөхцөлийг бүрдүүллээ.

Голомт банкны хувьд харилцагчдадаа дэлхийн жишигт нийцсэн банк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилгоор Харилцагч төвтэй банк-2020 стратегийг үйл ажиллагаандаа нэвчүүлэн ажиллаж байна.

Тус зорилтын хүрээнд “Харилцагч төвтэй салбарын бизнес модел” төслийг амжилттай хэрэгжүүлж, банкны бүтэц, зохион байгуулалт, систем, хүн хүч, тоног төхөөрөмж зэрэг процессын бүрэн шинэчлэлтийг хийв. Үүний үр дүнд харилцагчдад үзүүлэх үйлчилгээний хурд 27 хувь, ажилтнуудын сэтгэл ханамж, бүтээмж 30 хувь нэмэгдэж, банкны ашиг хоёр дахин өсөж, цэвэр хүүгийн өгөөж 3.3 хувьд хүрээд байна.

Бид Монгол Улсын өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнес эрхлэгчид болон томоохон компаниудад санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үзүүлж, дотоодын картын зах зээлийн 80 гаруй хувийг дангаар эзэлж байна.

Голомт банк нь салбарынхаа хөгжилд ямагт хурд нэмж ирсэн бөгөөд 2017 онд ч энэхүү амжилтаа бататгаж ажиллалаа. Монгол Улсад сүүлийн жилүүдэд интернэт болон ухаалаг гар утасны хэрэглээ хурдацтай өсөж, түүнийг дагасан бүтээгдэхүүн үйлчилгээ, контентийн агуулга өөрчлөгдөж, дижитал хэлбэрт шилжиж байна.

Техник технологийн хурдацтай хөгжил, дижитал эрин үе нь харилцагчдын зан төлөв, хэрэгцээ шаардлагыг уламжлалт банкны үйлчилгээнээс дижитал бүтээгдэхүүн үйлчилгээ рүү хөтөлж, сошиал харилцааг илүүд үзэх болжээ.

2017 онд Голомт банк нь SocialPay Fintech үйлчилгээ, Facebook messenger-т суурилсан Chatbot зэрэг харилцагч төвтэй үйлчилгээг Монгол Улсад анхлан нэвтрүүлээд байна. Мөн иргэдийн хуримтлуулах зуршлыг дэмжих, цаашилбал улс орны эдийн засгийг хөгжүүлэх зорилготой “Үндэсний хуримтлал”-ийн хөтөлбөрт 70 мянга гаруй харилцагчийг хамруулсан зэрэг өндөр амжилтыг үзүүллээ.

Бид 2016 онд алсын хараагаа “Дэлхийн жишиг Монголын банк” болно хэмээн тодорхойлсон. Энэхүү зорилтод хүрэхийн тулд ажилтнуудаа тасралтгүй хөгжүүлэхээс гадна харилцагчдадаа санхүүгийн боловсрол олгож, бизнесийг нь дэмжих зорилготой зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

Голомт банк нь Монгол Улсаас анх удаа НҮБ-ын Байгаль орчны сан (НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр-Санхүүгийн байгууллага)-ын идэвхтэй гишүүнээр элссэнийг баяртайгаар мэдэгдэхийн хамт үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд байгаль орчинд ээлтэй, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зарчмуудыг тусган ажиллаж байна.

Эрхэм хүндэт харилцагчид, хамтран ажиллагсад, түншүүд та бүхэндээ бидэнд ямагт өндөр итгэл хүлээлгэн, хувиршгүй сэтгэлээр дэмжиж, хамтран ажиллаж ирсэнд гүн талархал илэрхийлье.

Голомт банкны хоёр мянга гаруй шилдэг банкирууд, та бүхэнд дэлхийн жишигт нийцсэн банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхийн төлөө чин сэтгэлээсээ хичээнгүйлэн ажиллах болно.

Мөн харилцагчид болон төрөлх банкныхаа амжилтын төлөө өөрийн мэргэн ухаан, хичээл зүтгэлээ зориулан ажилладаг Голомтчууддаа талархлаа илэрхийлье.

2018 онд та бүхний ажил үйлс тань тэгш дүүрэн байж, амжилт бүтээлээр оргилон байхыг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн:

ТУЗ-ийн дарга



Ч.Мөнхцэцэг

Гүйцэтгэх захирал



Ө.Ганзориг



Бидний алсын хараа эрхэмсэг оршихуй СТРАТЕГИ

БИДНИЙ АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишиг Монголын банк


ЭРХЭМСЭГ ОРШИХУЙ

Хөгжлийн голомт

БИДНИЙ СТРАТЕГИ

Харилцагч төвтэй банк





СТРАТЕГИ ХЭРЭГЖИЛТ

Харилцагч төвтэй банк

Голомт банк нь харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг түрүүлж мэдрэн, хүлээлтээс нь давсан үйлчилгээг үзүүлэх Харилцагч төвтэй банк-2020 стратегийг үйл ажиллагаандаа нэвчүүлэн ажиллаж байна.

Харилцагч төвтэй салбарын бизнес модел төсөл

Голомт банк нь Харилцагч төвтэй банк-2020 үндсэн стратегийнхаа хүрээнд олон улсын тэргүүн туршлагад үндэслэсэн Харилцагч төвтэй салбарын бизнес загварыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж байна. Ажилчдын бүтээмж нэмэгдсэнээр харилцагч тав тухтай тохилог орчинд дэлхийн жишигт нийцсэн банкны бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлээд байгаа юм.

Дэлхийн жишиг Монголын банк болох зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн бизнес процесс ре-инженеринг төслийн хүрээнд банкны 250 гаруй гүйцэтгэлд нарийн дүн шинжилгээ хийсэн бөгөөд үүний үр дүнд харилцагчийн үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэх, зардлыг бууруулах, ажлын урсгалыг конвейерийн системд оруулах, салбарын бүтэц зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, технологийн шинэлэг шийдлийг нэвтрүүлэхэд чухал суурь нь болсон юм. Харилцагч төвтэй салбарын бизнес загварыг бий болгосноор:

Харилцагчдад:

Банкны үйлчилгээ харилцагчдад илүү энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй болсон.

Харилцагч салбар харгалзахгүйгээр үйлчлүүлдэг болсноор үйлчилгээ авах хурд 27 хувиар өссөн.

Ажилтанд:

Ажилтны ажлын чиг үүргийг дахин төрөлжүүлж, үйл ажиллагааны явцыг хөнгөвчилснөөр харилцагчдад үйлчлэх, борлуулалт хийх боломж нэмэгдсэн.

Ажлын гүйцэтгэлийн стандарт нормуудыг шинэчилж, цалингийн системтэй уялдуулсан нь ажилтны сэтгэл ханамж 30 хувиар өсөхөд нөлөөлсөн.

Банкинд:

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтыг хийж, эрсдэлийг бууруулан, тасралтгүй, найдвартай, хэвийн үйл ажиллагааны түвшинг нэмэгдүүлсний үр дүнд банкны ашигт ажиллагаа сайжрах боломж бүрдсэн.

Голомт банкнаас хэрэгжүүлсэн Харилцагч төвтэй салбарын бизнес модел нэвтрүүлэх төсөл нь банкны салбарын үйлчилгээний өнгө төрх, хөгжлийн хандлагыг шинээр тодорхойлж, харилцагчдын талархлыг хүлээсэн тул PMI Mongolia Chapter-аас Монгол Улсын 2017 оны шилдэг төслөөр модруулсан.

Харилцагчийн үйлчилгээний чанар, стандарт

Голомт банкинд харилцагчийн мэдрэмж, үйлчилгээний асуудлыг эрхэлсэн газрыг Харилцагчийн үйлчилгээний газар /ХҮГ/ нэртэйгээр байгуулав. ХҮГ нь харилцагчийн үйлчилгээний асуудлаас гадна Customer experience management буюу харилцагчийн мэдрэмжийн удирдлагыг сайжруулахад анхаарч ажилладаг бөгөөд үйлчилгээний стандартуудыг шинэчлэн баталсан.



Үйлчилгээний стандарт	Дэд бүлэг	Амжилт
Салбар тооцооны төвд баримтлах Харилцагчийн үйлчилгээний орчны стандарт	- Гадна - Дотоод тохижилт - Мэдээлэл хүргэлт - Бусад	Стандартыг нутагшуулах, биелэлтийг тогтмол хангаж ажилласнаар Улаанбаатар хот болон орон нутаг дахь салбар тооцооны төвүүдэд стандартын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт төлөвлөж байснаас 4 хувиар давсан бөгөөд цаашид жил бүр стандарт мөрдөлтийн түвшинг өсгөн чанарын сайжруулалтыг хийн ажиллах болно.
Харилцагчид үйлчлэх ажилтнуудын стандарт	- Харилцааны - Харагдах байдлын - Үйлчилгээ үзүүлэх - Борлуулалт	Ажилтнуудын хувьд бүтээгдэхүүн үйлчилгээний мэдлэгийг тогтмол сайжруулах системийг бий болгон мэдлэгийн түвшинг сайжруулснаар мэдлэгийн дундаж үзүүлэлт төлөвлөснөөс даруй 10 хувиар давсан байна.

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017

2016-2017 онд Голомт банкинд хэрэгжсэн Бизнес процесс ре-инженеринг төслийн хүрээнд харилцагчийн хувьд төвөгтэй байдаг зарим асуудлыг шийдвэрлэсэн.

- Харилцагчдад ойлгомжгүй байдаг зарим албан тушаалын нэршлийг өөрчилж, энгийн ойлгомжтой болгов
- Салбарын тохижилтод шинэлэг дизайныг нэвтрүүлсэн
- Ажилтан харилцагчидтайгаа хамгийн ойр буюу нүүр тулж үйлчлэх боломжтой тохижилтыг хийсэн
- Ажилтнуудын гадаад төрх, хувцаслалтыг шинэчилсэн зэрэг ажлууд хийгдсэн.

Харилцагчийн мэдрэмж, үйлчилгээний чухал ойлголт болох Харилцагчийн дуу хоолойн удирдлагыг сайжруулж, банкинд хандсан харилцагч бүрийн санал, хүсэлтийг түргэн шуурхай шийдэхийн төлөө ажилласан.

Шинэчлэгдсэн стандартын дагуу 2017 онд



800.000
хандалт
шийдвэрлэгдэж



зорилт
9.6% өссөн

Харилцагчийн хандах сувгийн төрөл



Утасны
дуудлага



И-мэйл



Facebook



Twitter



Viber

Онлайн банкны цахим
туслах болж өргөжсөн

Харилцагч хүссэн үедээ буюу 24 цагийн турш өөрийн боломжит сувгаар Голомт банктай холбогдож, асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой болсон. Харилцагчийн мэдрэмжийн удирдлагыг сайжруулахад харилцагчийн замналын /customer journey/ дагуу сайжруулалт хийх шаардлагатай байдаг. Иймд Голомт банк тус судалгааг тогтмолжуулж, харилцагчийн замналын цэгүүдийн чанарыг сайжруулах, чанарын удирдлагын тогтолцооны системийг бүрдүүлэн ажиллаж эхэллээ.

ИННОВАЦИ НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Монголын банк санхүүгийн салбарт Голомт банк нь бүтээгдэхүүн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл, сувгийн хөгжүүлэлтдээ инноваци нэвтрүүлэх, дижиталчлахад манлайлж, техник технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхдаг.

Тус банк нь Монгол Улсад анх удаа цахим банкны үйлчилгээг нэвтрүүлж, дижитал банкны суурийг тавьсан түүхэн гавъяатай бөгөөд орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан дижитал банкны бизнес загварыг амжилттай хэрэгжүүлсээр байна.

Тодруулбал, иргэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүссэн үедээ банкны харилцагч болох, үйлчилгээ авах боломжийг Монгол Улсад анхлан нэвтрүүлснээс гадна дараах онцлог бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд шинээр нэвтрүүлж, томоохон өөрчлөлтүүдийг хийсэн юм.

SocialPay финтех үйлчилгээ



Харилцагч уламжлалт бус дижитал банкны бүтээгдэхүүн үйлчилгээ рүү хөтлөгдөж, сошиал харилцааг илүүд үзэж буй энэ цаг үед Голомт банк нь Монгол Улсад анх удаа SocialPay финтех үйлчилгээг амжилттай нэвтрүүлээд байна. Ухаалаг гар утсанд суурилсан тус аппликейшний тусламжтайгаар facebook, twitter, и-мэйл хаяг болон утасны дугаар нь бүртгэлтэй хүмүүсийн жагсаалт, байршлыг ашиглан хамгийн хялбар аргаар төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг харилцагчдадаа олгосон юм.

Финтех үйлчилгээний боломжууд

- | | |
|--|---|
| | Утасны дугаар, и-мэйл болон twitter, facebook сүлжээ ашиглан мөнгө шилжүүлэх |
| | Харилцагчид хоорондоо чатлах үедээ мөнгө илгээх, төлбөр төлөх |
| | Мөнгө илгээх болон хүлээн авахдаа тусгай анимейшн бүхий бэлэг илгээх |
| | Бусдаас мөнгө авах хүсэлтээ нэхэмжлэх, QR кодоор гүйлгээ хийх |
| | Хэрэглээний төлбөрийн нэхэмжлэх хүлээн авах, төлөх |
| | Гар утасны дата болон нэгж цэнэглэх |
| | Интернэт худалдаа хийх |
| | Заавал банкны салбарт очилгүйгээр онлайнгаар банкны харилцагч болох |
| | Сошиал данснаа цэнэглэх, бусад банкны данс руу мөнгөө шилжүүлэх зэрэг
олон шинэлэг үйлчилгээг авах боломжтой юм |

Chatbot харилцагч төвтэй үйлчилгээ

Chatbot үйлчилгээ нь олон нийтийн томоохон сошиал сүлжээ болох facebook messenger-т суурилсан бөгөөд дижитал маркетинг, борлуулалт хийх боломжтой юм. Мөн харилцагчийн үйлчилгээ болон банкны үйлчилгээг дижитал хэлбэрээр хүргэх давуу талтай.

Chatbot үйлчилгээний боломжууд

	Сонирхсон асуултынхаа хариуг хамгийн оновчтойгоор, хормын дотор автоматаар авч цаг хугацаа хэмнэх
	Заавал банкинд очилгүйгээр Chatbot хөтчийн зааврын дагуу банкны бүтээгдэхүүн үйлчилгээг онлайнаар авах
	Банкны бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээлэл, валютын ханш, салбар АТМ-ын байршлын мэдээлэл авах
	Web-plugin ашиглан дансны үлдэгдлээ шалгах, гүйлгээ хийх, кредит картынхаа төлбөрийг төлөх боломжтой болсон

Internet & Smart bank-ны сайжруулалт

Голомт банк нь Internet & Smart bank-ны үйлчилгээг тасралтгүй сайжруулж, харилцагч төвтэй болгоход анхааран технологийн шинэ боломжийг тусгадаг.

Internet & Smart bank үйлчилгээний шинэ боломжууд

	Интернэт банкаараа зээл авах
	Дебит карт захиалах
	Тогтмол хийдэг төлбөр тооцоогоо захиалгат шилжүүлгэд даатгах
	Socialpay финтех үйлчилгээнд бүртгүүлэх
	Хурууны хээгээр нэвтрэх
	Хуримтлалын хадгаламж нээх
	Автомашинны торгууль төлөх
	Хадгаламж барьцаалсан зээл авах зэрэг үйлчилгээг авна

KIOSK

Банкны зээл авах, хадгаламж нээх, хуулга авах, тодорхойлолт хэвлэх, төлбөр төлөх, бүх төрлийн шилжүүлэг хийх зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломжтой автомат машиныг банкны секторт анхлан нэвтрүүлсэн.

Document Management System from Newgen /DMS/

Банкны хэмжээнд ашиглагдаж байгаа бүхий л баримт бичгүүдийг дижитал болгох, архивлах, үйл ажиллагааны процессийг автоматжуулах баримт бичгийн нэгдсэн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН



Үндэсний хуримтлалын хөтөлбөр

Иргэдийн хуримтлалыг өсгөх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой Үндэсний хуримтлалын хөтөлбөрт нийт 68 мянган иргэн нэгдээд байна. Тус хөтөлбөр нь сар бүр тогтмол дүнгээр орлогоо өсгөж, хуримтлуулах зуршлыг төлөвшүүлж чадсан харилцагчдад өндөр хүү, урамшуулал олгодгоороо давуу талтай. Мөн захиалгат шилжүүлэг хийж, хуримтлалын дансанд нь орлого хийх, хугацааг мессежээр сануулах, хуримтлал тань хэрхэн өсөх зэрэг мэдээллийг тогтмол өгдгөөрөө онцлогтой бүтээгдэхүүн юм.

Автодилерийн үйлчилгээ

2016 онд Голомт банк нь Монгол Улсад анх удаа Автодилерийн үйлчилгээг нэвтрүүлсэн. Тус үйлчилгээ нь автомашины чанарыг “Од”-оор илэрхийлэх бөгөөд харилцагч унаж буй машинаа урьдчилгаа төлбөрт тооцуулах, зөрүү төлбөрийг нь газар дээр нь Голомт банкны зээлээр төлөх зэрэг бүхий л үйлчилгээг нэг дор авах боломжтойгоороо харилцагч төвтэй үйлчилгээ юм.



Дараа төлбөрт Зэс карт

Зэс карт нь олон улсад эрхтэй төгрөгийн зээлийн карт юм. Тус карт нь урьдчилж зарцуулсан мөнгөө 45 хоногийн хугацаанд хүүгүй төлөх боломжтой, түрийвчнээс татаж авахад зориулагдсан хялбаршуулсан ховилтой, АТМ, Пос машинд уншуулахад чиглүүлсэн сумтай гэдгээрээ харилцагч төвтэй карт болж чадсан юм.



Голомт банк нь 2017 оны байдлаар Монгол Улсын кредит картын зах зээлийн 55 хувийг дангаар эзэлж байна. Энэ бүх амжилтыг үнэлэн Виза олон улсын байгууллага болон Мастер карт байгууллагаас Монголын шилдэг хамтран ажиллагч байгууллага, Шилдэг бизнесийн гүйцэтгэлтэй байгууллага, Шилдэг бүтээгдэхүүн нэвтрүүлэгч, Шилдэг инновацитай бүтээгдэхүүн зэрэг шагналуудыг олгоод байна.

12



Монгол Улсад анх удаа төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын олон улсын PCIDSS стандартын хамгийн сүүлийн 3.2 хувилбарыг, карт гаргагч болон хүлээн авагч хоёр талд зэрэг нэвтрүүлж, PCI консулаас батламжаа гардан авлаа.



Ган карт

Эх орондоо төдийгүй дэлхийн 168 оронд харилцагчийн санхүүгийн хэрэглээг ган мэт найдвартай хангаж, дэлхийг хэрсэн хөнгөлөлт урамшууллын сүлжээнд хамруулж, уян хатан зээлийн нөхцөлийг санал болгодог Ган төгрөгийн кредит картыг зах зээлд шинээр нэвтрүүлэв.



Сонгодог карт

Амьдралын хэв маягтаа тохируулан сонгодог Сувд, Карбон, Оюу картыг харилцагчдадаа зориулав.

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017

Банкны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн стандартчилал

Голомт банк нь 2016 онд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн моделтой болсноор бүтээгдэхүүн хөгжүүлэх ажлын дэс дараалал, заавал хийх тусгах ажлуудыг нэг бүрчлэн зааж, стандарт тогтоож өгснөөрөө онцлогтой юм. Уг моделийн дагуу хөгжүүлж, сайжруулсан бүтээгдэхүүний гүйцэтгэлийг 80 хувиас илүү байхаар төлөвлөн ажиллаж байна.

ДИГИТАЛ МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТ

Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг дижиталаар авах боломжийг харилцагчдад олгосноор кредит картын нийт борлуулалтын 37 хувийг дижитал борлуулалтаар хийв.

2017 онд



cards.mn
5000
карт борлуулсан



hurimtlal.mn
шинэчилж, ашиглахад
хялбар болсон



digital.golomtbank.com
банкны секторт
анхлан нэвтрүүлсэн

Голомт банк 2016.03-12 сар хүртэл Дижитал борлуулалт төслийг Монгол Улсад анх удаа хэрэгжүүлэхдээ дижитал борлуулалт хийх боломжтой бүтээгдэхүүний 30 хүртэлх хувийг тус аргачлалаар борлуулсан. Олон улсад дундаж борлуулалтын үзүүлэлт 2 хувьтай байхад хангалттай гэж үздэг нь тус төсөл амжилттай хэрэгжсэнийг харуулж байна.

ХАРИЛЦАГЧИЙН БОЛОВСРОЛД

Голомт банкны нийгмийн хариуцлагын гол зорилго нь харилцагчийн боловсролыг дэмжихэд оршдог.

Харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, зөвлөх үйлчилгээ хүргэх зорилгоор



шинэчилсэн
хувилбар



ceonetwork.mn

sme.golomtbank.com-ийн шинэчилсэн
хувилбарыг ашиглалтад оруулав

Дэлхийн санхүүгийн түүхийн музей


Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн харилцааны суурь мөн чанарыг ойлгуулах, санхүүгийн философиин нууцыг тайлах зорилгоор түүхийн хэмжээлшгүй үнэ цэнэтэй үзмэр бүхий Санхүүгийн түүхийн музейг үүсгэн байгуулсан юм.

Монголд төдийгүй Азид ганцханд тооцогдох тус музейд санхүүгийн зах зээлийн үндсэн бүрдэл болох мөнгө, банк, хөрөнгийн зах, даатгал, нягтлан бодох, төлбөр тооцоо, хуулийн чиглэлийн түүхэн баримтууд байх бөгөөд нийт үзмэрийн 98 хувь нь эх хувиараа хадгалагдаж байна.



Санхүүгийн философи ном

Санхүүгийн философи ном нь харилцагчдад дэлхийн санхүүгийн зах зээл, түүний үүсэл хөгжил, санхүүгийн суурь философи, мөн чанарыг хялбараар ойлгуулах зорилготой юм.



Нийгмийн хариуцлага

- Голомт банкны нэрэмжит Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг 2017 онд 17 дахь жилдээ зарлалаа.
- Голомт банк нийт 1300 оюутанд 1 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгоод байна
- Монгол үндэстний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах үйлсэд Голомт банк өөрийн хувь нэмрээ оруулан, Монгол Улсын Морин хуурын чуулгатай 6 дахь жилдээ хамтран ажиллаж байна.
- Дэлхийн болоод монголын сонгодог урлагийг түгээх, сурталчлах зорилгоор Голомт банк нь Дуурь бүжгийн эрдмийн театр болон Улсын драмын эрдмийн театрт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
- Монголын Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулиас хэрэгжүүлж буй Оюутны ногоон санаачилгын тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан төслийг Голомт банк санхүүжүүлж, хамтран ажиллахаар боллоо.
- Улаанбаатар хотын хөгжил дэвшил болон ажилтан албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангахад онцгой анхаарч буй 75 ААН-ийг шилдгээр тодруулахад Голомт банк 2016 онд 4,5 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн үндэслэлээр шалгарсан.
- Бизнес радио 98.9-тэй хамтарсан Таны санхүүгийн боловсролд нэвтрүүлгийг өдөр бүр харилцагчдад хүргэж байна.
- МҮОНТВ-ийн Өглөө хөтөлбөртэй хамтран Таны санхүүгийн боловсролд нэвтрүүлгийг бэлтгэн, харилцагчийн санхүүгийн боловсролыг дэмжин ажиллалаа.
- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн сахилга бат, хуримтлуулах зуршлыг төлөвшүүлэх зорилгоор Монголбанкнаас хэрэгжүүлсэн Санхүүгийн боловсрол аяны хүрээнд, 16 аймаг дахь салбарууддаа Дэлхийн хуримтлалын өдөрлөгийг зохион байгуулав.
- Орчин үеийн дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэгч Голомт банк нь хуримтлалын ач тусын тухай өгүүлэх видеог VR төхөөрөмж ашиглан хүргэх шинэлэг үйлчилгээг 5 салбар тооцооны төвд амжилттай туршив.
- Иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилготой нийтлэл, нэвтрүүлэг, видео, инфографик, quiz, 360 зураг зэрэг контентийг тогтмол бэлтгэн харилцагчдын хүртээл болгож байна.
- Голомт банк өөрийн санхүүжүүлсэн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллөөс болж үүссэн гомдлыг банкны Харилцагчийн үйлчилгээний газарт и-мэйлээр болон албан бичгээр хүлээн авч шийдвэрлэх механизмийг Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого буюу Байгаль орчин, нийгмийн бодлогодоо тусган хэрэгжүүлж эхэллээ.



Эдийн засаг БАНКНЫ СЕКТОР


2016 оноос эхлэн
Монголын эдийн
засаг эргэн өсөлтийн
замдаа орсон. 2017
онд тус нөхцөл байдал
үргэлжилсээр байв.



ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


Монголын эдийн засаг нь түүхий эдийн үнэ болон гадаадын шууд хөрөнгө оруулалтаас нягт хамааралтай байдаг. 2011 онд эдийн засгийн өсөлт 17 хувьд хүрч, гадаадын шууд хөрөнгө оруулалт 4 тэрбум ам.доллар давж байсан. Гэтэл олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ унаснаар валютын орох урсгал муудсан юм. Улмаар 2013 оноос эхлэн эдийн засгийн өсөлт саарсаар 2016 оны 3 улиралд хасах утгатай гарахад хүрсэн. Гэвч түүхий эдийн үнэ эргэн өсөлтийн замдаа орсноор 2016 оны 4 улиралд эдийн засгийн өсөлт ажиглагдаж, 2017 онд ч тус байдал үргэлжилж 5 хувийн өсөлтийг үзүүллээ.

Эдийн засгийн өсөлт 1990-2017 он
хувь



ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017


Гадаадын шууд хөрөнгө оруулалт
сая ам.доллар



Чухал өөрчлөлтүүдээс дурдвал төсвийн алдагдал 2017 онд өмнөх оноос 2 дахин буурч, гадаад худалдааны тэнцэл өмнөх оноос 50 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Монгол Улс сардаа дунджаар 2 сая тонн нүүрс экспортолдог байсан бол 3-4 сая тонн нүүрс экспортолж болсон нь гадаад худалдааны тэнцэл өсөхөд нөлөөлсөн юм.

Гадаад худалдааны тэнцэл
сая ам.доллар




Мөн нийт экспортын 40 орчим хувийг зэс, 15 орчим хувийг нүүрс эзэлдэг байсан бол нүүрс 35 орчим, зэс 25 орчим хувь болсон. Зэсийн үнийн хувьд 2017 онд мөн л өсөлттэй байв. Гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх жилээс 2 дахин өсөж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж буйг дараах үзүүлэлтээс харах боломжтой.

Монгол Улс 2017 оны 3 дугаар сард 600 сая ам.долларын үнийн дүнтэй Хуралдай бондыг 9 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээлд амжилттай гаргасан. 2017 оны 10 дугаар сард 800 сая ам.долларын үнийн дүнтэй Гэрэгэ бондыг 6 хувийн хүүтэйгээр босгож чадсан буюу 6 сарын дотор хүү 2 хувиар буурсан байна.

Зээлжих зэрэглэл

Мүүдиз агентлаг



Мөн 2017 оны 12 сард Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг эерэг болгон өөрчилсөн байна. Энэ нь 6 сараас 2 жилийн хугацаанд зэрэглэл өсгөх дохио болдог. 2018 оны 1 сард Мүүдиз агентлаг манай улсын зээлжих зэрэглэлийг Caa1-ээс B3 болгон сайжруулсан юм. Үүний үр дүнд ам.долларын ханш төгрөгийн эсрэг суларсан үзүүлэлттэй байлаа.

Цаашид үргэлжлэх валютын урсгал, эдийн



засгийн сэргэлт нь төгрөгийн ханшийг чанга байлгахад хүлээгдэж байна. 2017 онд хамгийн өндөр гүйцэтгэлтэй байсан салбарууд бол худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарууд байв. Уул, уурхайн салбарын үзүүлэлт бууралттай гарсан нь цэвэр Оюутолгойн зэсийн концентраци буурсантай холбоотой юм.

Харин нүүрсний компаниудын хувьд 2017 он нь маш эерэг жил болж чадсан. 2017 оны 4 улирлын эдийн засгийн өсөлтийн бүрэлдэхүүнийг харвал:

- Хөдөө аж ахуйн салбар 0.3 хувь
- Уул уурхайн салбар 1.7 хувь
- Боловсруулах үйлдвэр 1.4 хувь
- Барилга 0.2 хувь
- Худалдаа 1.7 хувь
- Тээвэр 0.8 хувь
- Үйлчилгээ 1.2 хувь
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 1.6 хувь байсан. Энэ нь тус улиралд нийт 5 хувийн өсөлтийг үзүүлэхэд нөлөөлсөн.

Эдийн засгийн өсөлтийн бүтэц

хувь



- Хөдөө аж ахуй
- Боловсруулах үйлдвэрлэл
- Бөөний болон жижиглэнгийн худалдаа
- Уул уурхай
- Барилга
- Тээвэр


БАНКНЫ СЕКТОР

Монгол Улсад хэрэгжиж байгаа ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Активын чанарын үнэлгээ нь банкны салбарт тохиосон томоохон үйл явдал байв. Тус үнэлгээгээр Монгол Улсын банкны салбарын төлбөрийн чадвар бүхэлдээ тогтвортой, системийн хэмжээнд төлбөр түргэн

гүйцэтгэх харьцаа үзүүлэлт 45 хувь, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 14 хувьтай байв. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан банкны ашигт ажиллагаа сайжирч, хүү буурч байна.


Өөрийн хөрөнгийн өгөөж

хувь



Бодлогын хүү

хувь



ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017


Мөнгөний нийлүүлэлт 2017 онд жилийн 30 хувийн өсөлттэй гарч 15,8 их наяд төгрөгт хүрсэн. Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг харвал төгрөгийн хадгаламж хамгийн өндөр буюу 49 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

Харин гадаад валютын хадгаламж 2016 оны эцэст 46 хувийн өсөлттэй буюу 2,8 их наяд төгрөг байсан бол 2017 онд 9 хувиар буурч 2,5 их наяд төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлтийн өндөр өсөлт нь банкны салбарт төдийгүй зээлийн хувьд ч дэмжлэг болж байгаа юм.

2017 оны дунд үеэс эхлэн мөнгөний нийлүүлэлт зээлийн үлдэгдлээс өндөр болсон нь 2009 оны хямралын дараах үетэй ижил түвшинд ажиглагдаж байна. 2013 оноос эхлэн зээлийн дүн, мөнгөний нийлүүлэлтээ гүйцсэн. Энэхүү нөхцөл байдал нь ойрын 2-3 жилийн хугацаанд давтагдахаар хүлээгдэж байна.

Мөнгөний нийлүүлэлт болон Зээл


их наяд төгрөг



Ам.долларын ханш төгрөгийн эсрэг суларсантай холбоотойгоор харилцагчаас татсан эх үүсвэрийн долларжилт жилийн хугацаанд 37 хувиас 29 хувь болж буусан үзүүлэлттэй байлаа. Банкны өөрийн хөрөнгийн хувьд 2017 онд 7 хувиар, жилийн ашиг 41 хувиар өссөн. Өөрийн хөрөнгийн өгөөж 1.4 нэгж хувиар өсч 8 хувь, активын өгөөж 0.2 нэгж хувиар өсөж 0.9 хувь байна.

Зээлийн чанаргүйдэл

хувь



Ийнхүү банкны салбарын нийт активын хэмжээ 2017 онд өмнөх оноос 14 хувиар өсөж 28,8 их наяд төгрөгт хүрсэн. Активын бүтцэд гарсан гол өөрчлөлт нь гадаад актив 37 хувиар буурсан, Засгийн газрын үнэт цаас 27 хувиар буурсан байна. Нөгөө талаас Төв банкны үнэт цаас 6 дахин өсөж 3,4 их наяд төгрөгт хүрсэн. Харин нийт зээлийн үлдэгдэл 10 хувиар өссөн байна. Сегментээр авч үзвэл иргэдийн зээл 18 хувиар өссөн бол байгууллагын зээл 3 хувиар буурсан байна.

Зээлийн чанаргүйдлийн хувьд өмнөх онтой адил 9 хувьтай байлаа. Энэ нь эдийн засгийн өсөлт нь зээлийн чанаргүйдэлд хараахан бодитоор хүрч чадаагүй байгааг харуулж байна. Иймд эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор ирэх онуудад активын хөрөнгийн чанаргүйдэл буурахаар хүлээгдэж байна.

« Байгууллагын үйлчилгээ
Corporate service

АЛСЫН ХАРАА
Дэлхийн Жишиг Монголын Банк

ЭРХЭМСЭ
Хөгжлийн Гол

ТАНД ТУСАЛЪЯ

Вип үйлчилгээ
VIP service

Г ОРШИХУЙ
ГОЛОМТ

Голомт банкны САНХҮҮГИЙН ҮР ДҮН


2 017 онд Голомт банкны харилцагчаас татсан эх үүсвэр 23 хувиар нэмэгдсэнээр Монголын нийт эдийн засгийн 19 хувьтай тэнцэхүйц хөрөнгийг удирдаж байна.

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Ашигт ажиллагаа

2017 онд Голомт банкны цэвэр хүүгийн орлого 43 хувь, цэвэр шимтгэлийн орлого 27 хувиар өссөн. Тус онд үйл ажиллагааны ашигт своп хэлцлийн 43 тэрбум төгрөгийн бүртгэлийн гарз нөлөөлснөөр өмнөх оноос буураад байгаа ч хэрэв свопын нөлөөг хасч тооцвол үйл ажиллагааны орлого 38 хувь, үйл ажиллагааны ашиг 80 хувь өссөн үр дүнтэй байлаа.

Үйл ажиллагааны орлого
тэрбум төгрөг




Үйл ажиллагааны ашиг
тэрбум төгрөг




Актив пассивын оновчтой удирдлага, зардлын менежментийн үр дүнд ашигт ажиллагааны харьцаанууд сайжирсан байна. Банк орлого олдог активынхаа хэмжээг нэмэгдүүлж, зээлийн эргэн төлөлтүүд дээр сайн ажилласантай холбоотойгоор цэвэр хүүгийн ахиуц 2.8 хувиас 3.3 хувь болж өссөн.

Мөн оновчтой, үр ашигтай зардлын менежментийн үр дүнд зардал орлогын харьцааг свопын нөлөөгүй тооцоход 61 хувиас 49 хувь болж сайжирсан байна.

Цэвэр хүүгийн ахиуц
хувь



Зардал орлогын харьцаа
хувь



Балансын гол өөрчлөлт

Нийт актив

тэрбум төгрөг



Харилцах, хадгаламж

тэрбум төгрөг




ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017


Голомт банкны нийт актив 2017 онд 546 тэрбум төгрөг буюу 12 хувиар өсөж, 5,2 их наяд төгрөгт хүрсэн.

Пассивын бүтэц

2016 он



2017 он



Пассивын бүтцийн хувьд авч үзвэл 2016 онд харилцагчдын эх үүсвэр нийт пассивын 67 хувийг эзэлж байсан бол 2017 онд 73 хувь болж өссөн байна.

Харилцагчдаас татсан эх үүсвэр 2017 онд 651 тэрбум төгрөг буюу 23 хувиар өссөн. Энэхүү өсөлтөд иргэдийн эх үүсвэр голлох нөлөө үзүүлсэн бөгөөд нийт өсөлтийн 60 орчим хувийг эзэлж байна.

Харин зээлсэн эх үүсвэр 2016 онд нийт эх үүсвэрийн 28 хувийг эзэлж байсан бол 2017 онд 16 хувь болж буурсан нь Чингис бондын 217 тэрбум төгрөг, гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан 100 сая долларын зээлийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой юм.

Активын бүтэц

2016 он




2017 он



Нийт активт эзлэх орлого олдог актив /зээл, үнэт цаас/ багц 59 хувиас 69 хувь болж актив ашиглалт сайжирсан. Ностро дансны бууралттай холбоотойгоор банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө нийт активын 17 хувийг эзэлж байсан бол 11 хувь болж буурсан.


Цэвэр зээл

тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгө

тэрбум төгрөг



Зээл

Нийт зээл 2017 онд 288 тэрбум төгрөг буюу 14 хувиар өссөн. Энэ өсөлтөд хэрэглээний зээл гол нөлөө үзүүлсэн бөгөөд 215 тэрбум төгрөг буюу 84 хувиар өсөөд байна. Энэ нь Голомт банкны хэрэгжүүлж буй Харилцагч төвтэй стратегийг хэрэгжүүлсний үр дүн юм.

Өөрийн хөрөнгө


2017 онд Голомт банкны өөрийн хөрөнгө 35 тэрбум төгрөг буюу 8 хувиар өсөж 489 тэрбум төгрөгт хүрээд байна.

Зохистой харьцаа

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн төвлөрөл, төлбөрийн чадвар, гадаад валютын эрсдэлтэй холбоотой бүхий л үзүүлэлтээр Монголбанкнаас тавьдаг шалгуурыг бүрэн хангаж ажиллалаа.


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ > 14%

хувь



Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар > 25%

хувь



Голомт банкны сүүлийн 5 жилийн санхүүгийн үр дүн

Үзүүлэлтүүд (сая.төг)	2013	2014	2015	2016	2017
Нийт харилцагчийн харилцах, хадгаламж	2,161,779	2,232,270	2,079,801	2,803,328	3,453,920
Зээлээр авсан эх үүсвэр	1,032,319	1,011,499	1,014,935	1,195,870	757,897
Цэвэр зээл	2,199,228	2,461,920	2,013,611	2,034,860	2,318,058
Нийт өөрийн хөрөнгө	329,740	393,736	428,181	453,707	488,675
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	290,945	338,366	314,830	331,900	409,220
Хүүгийн зардал	(184,701)	(209,312)	(213,295)	(246,416)	(287,230)
Цэвэр хүүгийн орлого	106,245	129,054	101,534	85,484	121,990
Цэвэр хүүгийн бус орлого	59,774	36,197	58,454	63,200	8,615
Свопын нөлөө	-	-	41,041	22,376	(43,217)
Үйл ажиллагааны орлого	166,019	165,251	159,988	148,684	130,605
Үйл ажиллагааны орлого -свопын нөлөө хассан		165,251	118,947	126,308	173,822
Үйл ажиллагааны зардал	(67,116)	(73,068)	(75,362)	(77,251)	(85,583)
Үйл ажиллагааны ашиг	98,903	92,182	84,626	71,433	45,021
Үйл ажиллагааны ашиг -свопын нөлөө хассан	98,903	92,182	43,585	49,057	88,238
Эрсдэлийн сангийн зардал	(27,940)	(27,900)	(51,900)	(58,686)	(36,947)
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт					(20,158)
Татварын өмнөх ашиг	70,963	64,283	32,726	12,746	(12,083)
Татварын зардал	(14,106)	(14,455)	(6,742)	(7,473)	6,930
Татварын дараах ашиг	56,857	49,828	25,985	5,274	(5,153)
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	57.7%	55.1%	54.7%	60.2%	66.4%
Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл)/ Нийт актив (%)	6.6%	7.2%	8.3%	6.7%	6.2%
Цэвэр зээл / Нийт актив (%)	58.6%	60.7%	52.9%	43.7%	44.5%
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.6%	4.5%	4.2%	2.8%	3.3%
Зардал, орлогын харьцаа (%)	40.4%	44.2%	47.1%	52.0%	65.5%
Зардал, орлогын харьцаа -свопын нөлөө хассан (%)	40.4%	44.2%	63.4%	61.2%	49.2%
Шалгуур үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >14%	16.7%	17.1%	16.6%	14.8%	14.4%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын хувьд <+/-40%	7.0%	9.9%	12.0%	15.0%	16.3%
Нэгж гадаад валютын хувьд <+/-15%	-6.2%	-9.5%	10.7%	7.5%	11.8%
Нэг зээлдэгчид олгосон зээлийн харьцаа <20%	15.9%	15.8%	18.2%	18.5%	16.8%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа <5%	3.0%	4.6%	3.9%	4.6%	4.2%
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн харьцаа <20%	8.2%	15.8%	17.0%	17.0%	17.9%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >25%	43.3%	38.2%	38.1%	44.8%	44.5%
Үндсэн хөрөнгийн харьцаа <8%	1.4%	2.3%	4.7%	5.1%	4.8%



Бизнесийн ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт банк харилцагч төвтэй банк байх стратегийн хүрээнд монголын ТОП-250 компанийн эзэд болон гүйцэтгэх захирлуудыг хамруулсан Голомт Менежмент форум-2017 чуулга уулзалтыг 2017 онд амжилттай зохион байгууллаа.

ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй жижиг дунд бизнес эрхлэгчид болон иргэдийн санхүүгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн иж бүрэн үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэж, улмаар тэдний өсөлт хөгжилтөд хувь нэмэр оруулах нь Голомт банкны гол зорилго юм. Голомт банк нь Улаанбаатар хот болон орон нутаг дахь нийт 100 гаруй салбар нэгжээрээ дамжуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагад дэлхийн жишигт нийцсэн санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үзүүлж, тогтмол өсөлтийг үзүүлсээр байна.

Банкны салбарт 2017 он



Картын зах зээл



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Банк нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монголын банк санхүүгийн салбарын хөгжилд хурд нэмсэн анхдагч олон алхмыг хийж ирсэн бөгөөд энэ амжилтаа улам бататган ажиллаж байна.

Монгол Улсад анх удаа



ЖИЛИЙН ТАЙЛАН 2017



БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

Банкны салбарт



Нийт харилцагч байгууллага

800

Яам, Элчин сайдын яамд, ТОП ААН-үүд



Худалдааны санхүүжилт

2-т ордог

26%



Байгууллага ЖДБЭ-ийн хадгаламж

2-т ордог



Байгууллагаас татсан эх үүсвэр

Өсөлт 18%



Байгууллагад олгосон зээл

Өсөлт 41%

20.5%



ЖДББ-аас татсан эх үүсвэр

Өсөлт 26%

Бид харилцагч байгууллагуудтайгаа хамтран 2017 онд хэд хэдэн томоохон арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Менежментийн форум

Голомт банк харилцагч төвтэй банк байх стратегийн хүрээнд монголын ТОП-250 компанийн эзэд болон гүйцэтгэх захирлуудыг хамруулсан Голомт Менежмент форум-2017 чуулга уулзалтыг 2017 онд амжилттай зохион байгууллаа. Тус форумын гол онцлог нь бодит үр дүн, сайжруулалтыг бий болгосон менежментийн шилдэг, шинэлэг технологи, арга барил, ололт амжилт, туршлага, ур чадварынхаа нууцаас бусадтайгаа хуваалцаж, харилцан туршлага солилцсоноороо Монгол Улсын бизнес, менежментийн салбарын хөгжилд цоо шинэ хуудсыг нээсэн юм.

Бизнесийн зөвлөх үйлчилгээний форум

Голомт банк Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтарч бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээний ач холбогдлыг таниулах зорилгоор Бизнесийн зөвлөх үйлчилгээний форумыг амжилттай зохион байгууллаа.

Дижитал шилжилт конференц

Голомт банк Монгол Улсад анх удаа Дижитал шилжилт конференцийг зохион байгуулсан бөгөөд дижитал шилжилтэд үзүүлэх төрийн оролцоо, дижитал бизнес, маркетинг, борлуулалт, финтек бүтээгдэхүүн болон түүний суурь болох технологийн шийдэл, мэдээллийн аюулгүй байдлын асуудал, дижитал шилжилтийн иргэдэд үзүүлэх үр дүн зэрэг өргөн сэдвийг хөндсөн юм.

Бусад арга хэмжээ

- Алтны салбарын хөрөнгө оруулагчдын дунд зохион байгуулагддаг Монгол алт 2017 чуулганы ивээн тэтгэгч банкаар оролцлоо.
- Монгол Улсын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж буй нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдыг татах, шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилготой Coal Mongolia чуулганыг ивээн тэтгэлээ.
- Голомт банкны 2014 онд нэвтрүүлсэн Инфосис системд үндэслэж Монгол Улсад анх удаа байгууллага, банкиг холбосон Корпорейт гейтевей үйлчилгээг нэвтрүүлснээр байгууллагын санхүүгийн ажилтнуудын ачааллыг 50 хувиар бууруулж, гүйлгээний хурдыг хоёр дахин өсгөлөө.
- Их дээд сургуулиудад цахим төлбөр тооцоо, онлайн үйлчилгээг хөгжүүлж, оюутан сурагчдад зориулсан сургалтын төлбөрийн зээл, картын цогц шийдэл зэргийг агуулсан багц үйлчилгээг нэвтрүүлэв. Мөн оюутан залуусын оюуны боловсролыг дэмжих үүднээс Монгол Улсын Цахим номын санд Голомт банкны нэрэмжит танхимыг нээлээ.

Уул уурхай, дэд бүтцийн салбарт



Нүүрсний салбарыг тодорхойлогч үндэсний компаниудтай хамтран ажиллаж нийт нүүрсний экспортын орлогын 32 хувийг төвлөрүүлсэн



Оюу Толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын барилга байгууламжийн гүйцэтгэгч үндэсний болон гадаадын аж ахуйн нэгжүүдэд банкны цогц үйлчилгээг үзүүллээ



Эрдэнэтийн-Овоо ордын хүдэрт тохирсон эрдсийн өгөгдлийн сан үүсгэх, эрдсийн нарийн шинжилгээ хийх зориулалт бүхий TEMSCAN анализаторыг Чех улсын банкттай хамтран санхүүжүүлэв



Улаанбаатар хотод Клинкер боловсруулах үйлдвэрийн төслийн санхүүжилтийн төлбөр баталгаажуулагч банкаар ажиллав



Монгол Улсын шатахууны хэрэгцээний 90 хувийг гүйцэтгэдэг компаниудтай хамтран ажиллаж, импортолсон нийт шатахууны 25 хувийг олон төрөлтөд санхүүжилтийн хэрэгслээр гүйцэтгэв.

Эдийн засгийн төрөлжүүлэлт, хөгжлийг дэмжих чиглэлд хамтран ажилласан төсөл хөтөлбөрүүд

2017 онд Голомт банк нь дотоод, гадаадын нийт 13 төслийн эх үүсвэртэй хамтран ажиллаж байна.

Төслийн санхүүжилтийн хүрээнд



АХБ болон Монгол Улсын Сангийн Яамны хөнгөлөлттэй санхүүжилтээр олгогдох Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслийн зээл олгож байна



Засгийн газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлийг олгох эрх бүхий цорын ганц банкаар шалгаран ажиллаж байна



Засгийн газрын Ноос, ноолуур үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжих хөтөлбөр, Махны нөөц бүрдүүлэх үндэсний хөтөлбөрт зээл олгох, гүйцэтгэх банкаар шалгарав



ХНХХЯ-тай хамтран 20 тэрбум төгрөгийн ажлын байр нэмэгдүүлэх зээлийг Монгол Улсын 21 аймаг 9 дүүрэгт хэрэгжүүлсэн.



Ноос, ноолуур, сүү, оёмол сүлжмэл болон хүлэмжийн аж ахуй эрхлэгч 169 харилцагчид 225,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.4 хувийг эзэлж байна. Эх үүсвэрийг 2017.12.01-нд Монгол Улсын Хөгжлийн банкинд төлж барагдуулсан.



Засгийн газрын Ажлын байр нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэгч банкаар Голомт банк дангаар шалгарч нийт 12 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1112 бизнес эрхлэгчдэд олгож 5175 ажлын байр шинээр бий болгов.

ГАДААД ЭХ ҮҮСВЭР, ХАМТЫН АЖИЛЛАГАА

2017 онд гадаадын банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, зээлийн шугамын хэмжээ 175 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ.


Нийт харилцагч банк санхүүгийн байгууллагууд



- 30 Корреспондент харилцаатай банкууд
- 30 Худалдааны санхүүжилтийн чиглэлээр хамтын ажиллагаатай банкууд
- 10 Даатгалын агентлагууд
- 5 Хөгжлийн санхүүгийн байгууллагууд
- 11 Гишүүн байгууллагууд
- 17 Бусад

2017 онд нэмэгдсэн гадаад эх үүсвэр, санхүүжилт


- АНУ-ын засгийн газрын Overseas Private Investment Corporation /OPIC/-ын баталгаатайгаар АНУ-ын WorldBusiness Capital Inc., байгууллагатай 8 жилийн хугацаатай зээлийн гэрээг байгуулж санхүүжилт авлаа. Энэхүү зээл нь хөдөө аж ахуйн сектор болон жижиг дунд бизнесийг хөгжүүлэхэд чиглэсэн урт хугацааны санхүүжилт юм.
- АНУ-ын Хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөрийн хүрээнд USDA /United States Department of Agriculture/-ын баталгаатайгаар Cargill Inc. олон улсын байгууллагатай зээлийн гэрээ байгуулан санхүүжилт татав.
- Нидерландын Lendahand B.V-тай 4 жилийн хугацаатай гэрээ байгуулан жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан урт хугацааны санхүүжилтийг нэмэгдүүлэв.
- Японы SMBC банк, Туркийн EXIM банк, Оросын EXIM Банк, IBEC /International Bank for Economic Co-operation/ зэрэг банкуудтай шинээр худалдааны санхүүжилтийн зээлийн шугам тогтоож, экспорт импорт эрхлэгч аж ахуйн нэгжүүдийнхээ санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлсээр байна.



Гадаад харилцаа хамтын ажиллагаатай банк санхүүгийн байгууллагууд



Олон улсын байгууллага дахь гишүүнчлэл



Худалдааны санхүүжилт

Голомт банк нь хил дамнасан худалдааны бизнес эрхлэгчдийн бараа эргэлтийг нэмэгдүүлэх, төлбөр тооцоо, худалдан авалтын эрсдэл, санхүүжилтийн өртгийг бууруулахад онцгой анхааран ажиллав.

34

Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн

-  Экспорт, импортын аккредитив
-  Гадаадын банкны эх үүсвэртэй импортын зээл
-  Экспортын даатгалын агентлагаар даатгагдсан дунд болон богино хугацаат зээл /ЭСА зээл/
-  Бүх төрлийн гадаад баталгааны үйлчилгээ

Банкны салбарт 2017 он



Худалдааны
санхүүжилтийн
нийт багц

\$117,9 саяд
хүрч
83.26% өсөв



Гадны банкуудаас
батлуулсан шугам
ашиглалтын хэмжээ **58%** хүрч
40% өсөв



Аккредитивийн тоо
26%
2-т жагсав



БНХАУ-ын банкууд
руу нээсэн нийт
аккредитив

60%
дангаар нээв



Экспортын аккредитив
41%
дангаар гүйцэтгэв



Импортын аккредитив
саяд хүрч
\$54,9 **2 дахин өссөн**

2017 онд Голомт банк харилцагчдынхаа гадаад худалдааны бизнесийг дэмжих зорилгоор Хятад, Япон, Солонгос, Герман, Испани, Нидерланд, Дани, Итали, Франц, Турк, АНУ, ОХУ, Сингапур, Малайз, Вьетнам, АНЭУ зэрэг дэлхийн өнцөг булан бүрээс хийгдсэн импортыг санхүүжүүллээ.

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017

Импортын аккредитивийн
зах зээлд Голомт банкны эзлэх хувь



• 26%

Экспортын аккредитивийн
зах зээлд Голомт банкны эзлэх хувь



• 41%

Голомт банк харилцагчдынхаа тоног төхөөрөмж, хүнд даацын автомашины худалдан авалтыг санхүүжүүлэхэд Чех, Бельги, Герман улсын томоохон банкууд болон экспортын даатгалын агентлагуудтай хамтран ажилласан. Мөн Европын холбооны улс орны банкуудтай хамтран, хөдөө аж ахуйн зориулалттай сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, технологийг дотоодын зах зээлд нэвтрүүлээд байна.

Гадаадын банкны эх үүсвэртэй зээл олголт 2017 он

Дэд бүтэц | Харилцаа холбоо | Зам тээвэр | Барилга байгууламжийн түүхий эд | Тоног төхөөрөмж

₮49 тэрбум

Боловсруулах үйлдвэрийн түүхий эд | Тоног төхөөрөмж

₮100 тэрбум


Хүнс | Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн

₮40 тэрбум

АРИЛЖАА, НӨӨЦИЙН УДИРДЛАГА

2017 онд ам.доллар болон төгрөгийн ханш 2350-2498 төгрөгийн хооронд өндөр хэлбэлзэлтэй байсан ч, Голомт банк валют арилжааны зах зээлд B-Match-ийн хоёр гол дилерийн нэг байж, банк хоорондын валют арилжааны 35 хувийг гүйцэтгэсэн.

Монголбанкинд тушаасан алтны хэмжээгээр зах зээлд эзлэх хувь 2017 он



Голомт банк нь харилцагчдадаа валютийн ханшийн эрсдэлээс хамгаалах хеджийн бүтээгдэхүүнийг санал болгож ажилласнаас гадна байгууллагын харилцагчидтай хийх дотоодын валют арилжааг 53 хувиар өсгөсөн юм. Мөн банк нь санхүүгийн зах зээлд эзлэх хувиа ашиглаж, биет алтны арилжааг 12 дахин нэмлээ.

2017 онд банкны хөрвөх чадвар сайн байсан тул илүүдэл нөөцөө ам.доллар, төгрөгийн үнэт цаас болон засгийн газрын бондод оруулж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлсэн. Мөн Монголын хөрөнгийн бирж, Төв банкны систем дээр арилжаалагдаж байгаа Монгол Улсын Засгийн газрын өрийн хэрэгслүүдийн арилжаанд голлох үүргийг гүйцэтгэсэн.



Дотоод ҮЙЛ АЖИЛЛАГАА

Алсын хараа, бизнесийн зорилгод нийцсэн үр ашигтай эрсдэлийн удирдлага нь эдийн засгийн ямар ч нөхцөлд амжилттай ажиллах гол үндэс болдог төдийгүй банкны стратеги зорилтуудыг биелүүлэх хөшүүрэг мөн.

ХҮНИЙ НӨӨЦ

Хүний нөөц




Сургалт хөгжүүлэлтийн чиглэл




Сургалт хөгжүүлэлтийн зардал

56% өссөн




Сургалтад хамрагдсан ажилчид

97% өссөн



Нийт сургалтын хүн цаг

2.2 дахин өссөн



Сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд



Зуны Академи

Нийт ажилтны хөгжлийн хөтөлбөр

Голомт банкны удирдах ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх зорилгоор зуны турш буюу 2 сарын хугацаанд хэрэгжүүлсэн Leadership&People management 43 цагийн 4 үндсэн модуль бүхий цогц хөгжлийн хөтөлбөрт 240 гаруй удирдах ажилтан хамрагдлаа. Удирдах ажилтан бүр өөрийн сурсан мэдлэгээ ажилтнуудтайгаа хуваалцаж, банк даяар түгээснээр бүгд нэг ойлголттой болж, нэг хэлээр ярьдаг болсноороо онцлогтой байв.



Санхүүгийн Ментор

Борлуулалтын ажилтны хөгжлийн хөтөлбөр

Эмпатид суурилсан борлуулалтын стратегийг хэрэгжүүлэх зорилго бүхий энэхүү хөтөлбөрийн хүрээнд 13 ментор сонгогдсон. Тус хөтөлбөрт борлуулалтын 200 гаруй ажилтан хамрагдсан бөгөөд 2018 онд хөтөлбөр үргэлжилнэ.

Удирдах ажилтанд зориулсан цогц хөтөлбөр

- Нийт захирлуудад зориулсан Бид банкаа манлайлна удирдах ажилтны семинар
- Бүтээмж DD workshop хэлтсийн захирлуудын хэлэлцүүлэг
- Салбарын захирлуудын хөгжлийн хөтөлбөр
- Салбарын захирал бэлтгэх симуляци сургалт–БСА
- Ярих, илтгэх ур чадварыг хөгжүүлэх зорилготой СУИС-ийн тайзны урлагийн багш н.Уртнасантай хамтарсан 2 сарын сургалт
- Ахлах менежер бэлтгэх сургалт гэх мэт сургалтууд оров.

40

Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөр

Голомт банкны шинэ ажилтны хүлээлтийг удирдах зорилго бүхий New employee onboarding program-ийг ажилд орсон анхны өдрөөс эхлэн үндсэн ажилтнаар томилогдох хүртэл хугацаанд дараах 3 түвшинд шинэчлэн хэрэгжүүлж эхэллээ.

- Харилцааны менежер, банкируудад зориулсан чиглүүлэх хөтөлбөр
- Төвийн нэгжийн ажилтны чиглүүлэх хөтөлбөр
- Салбарын удирдах ажилтны чиглүүлэх хөтөлбөр

Мэргэшүүлэх сургалтууд

2017 онд сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу техник, мэргэжлийн болон бусад ур чадварыг хөгжүүлэх, эзэмшүүлэх сургалтуудыг явууллаа. Тус сургалтад нийт 31 ажилтан амжилттай хамрагдсаны 23 нь мэдээллийн технологийн ажилтнууд байна.



Банкны үнэ цэнэ

Нийт ажилтны сургалт

Байгууллагын шинэчилсэн үнэт зүйлсийг танилцуулах сургалтыг 40 жилийн туршлагатай Японы U Норе ХХК-ийн захирал Abe Tadashi багштай хамтран зохион байгуулсан бөгөөд 800 ажилтан хамрагдав.



Амжилтын баяр 2017

Голомт банк 2016 оноос эхлэн банкинд онцгой хувь нэмэр оруулсан 1 ажилтныг тодруулж, автомашин зэрэг томоохон шагналыг гардуулдаг уламжлал тогтоод байна. 2017 онд Голомт банк 1 хүнийг Од ажилтнаар шалгаруулж LEXUS машин, 2 хүнийг Од менежерээр шалгаруулж орон сууцны түлхүүр гардуулан өгөөд байна.

Од ажилтан

С.ТУЛГА /Кастодиан банкны хэлтэс, Ахлах менежер/



Кастодиан банкны хэлтсийн ахлах менежер С.Тулга нь дэлхийд тэргүүлэгч глобал кастодиан банктай Голомт банкиг амжилттай хамтын ажиллагаа өрнүүлэхэд нь онцгой хувь нэмэр оруулан ажилласан тул 2017 оны "Од" ажилтнаар тодорчээ. Мөн тэрбээр олон улсын кастодиан банкуудад ашигладаг СВИФТ стандартад нийцсэн тест болон банкны өргөтгөсөн KYC due diligence процессыг амжилттай нэвтрүүлэхэд өндөр хувь нэмэр оруулсан юм. Түүнчлэн Кастодиан банкны хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллагуудтай тогтоосон харилцаа холбоог өргөжүүлэх, кастодианы үйл ажиллагааг дэмжсэн зах зээлийн шинжтэй өөрчлөлт, хөгжүүлэлтүүдийг хийхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн байна.

Од менежер

Б.ЭНХТҮВШИН /Замын-Үүд тооцооны төв Захирал/

42

Голомт банкны Замын-Үүд тооцооны төв нь тухайн орон нутгийнхаа зах зээлийн 20-оос дээш хувийг эзэлсэн 2 том банкны нэг болж, 2017 онд тус төвийн 10 жилийн турш хуримтлуулсан орлогоос давсан ашгийг бүрдүүлсэн байна. Тодруулбал зээлийн багцыг 11 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн бөгөөд нэгжийн ашигт ажиллагаагаар орон нутгийн нэгжүүдээс TOP-5 нэгжийн 4-т орж, орон нутгийн салбар нэгжүүдээс анх удаа 10 тэрбумаас давуулсан амжилт үзүүлээд байна.

Од менежер

У.БЯМБАСҮРЭН /Зээлийн газар, Жижиг дунд зээлийн хэлтэс, Захирал/

У.Бямбасүрэн нь 2017 онд нийт 1470 харилцагчийн 915 тэрбум төгрөгийн зээлийн шийдвэр гаргалтад бодлого, борлуулалтыг дэмжин амжилттай ажилласны зэрэгцээ 17,6 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг сайжруулах ажлыг гардан гүйцэтгэсэн. Тэрбээр Зээлийн процесс шинэчлэх ажлын хүрээнд жижиг дунд зээлийн судалгааг хэлтэстээ төвлөрүүлснээр зээлийн судалгааны чанар, хурд, үр ашгийг 2-3 дахин нэмэгдүүлсэн юм. Ингэснээр жижиг дунд бизнесийн зээлийн багц 468 тэрбум төгрөгт хүрч, 3 дахин өссөн байна.



Мөн 2017 онд хамт олноо ажил үйлсээрээ хошуучлан манлайлсан шилдэг 12 ажилтныг тодруулж, өргөмжилсөн юм.

Голомтын шилдгүүд

Г.Урангоо	Орхон салбар	Үйл ажиллагааны ахлах ажилтан
Б.Галбадрах	Их Монгол тооцооны төв	Захирал
О.Өлзий-Орших	Оюутолгой тооцооны төв	Харилцааны менежер
Т.Мөнх-Эрдэнэ	Төв бизнес төв	Харилцааны ахлах менежер
Н.Батсүрэн	Дижитал банкны хэлтэс	Ахлах бизнес аналит
З.Ганбагана	Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс	Мэдээллийн аюулгүй байдлын шинжээч
С.Ариунжаргал	Санхүү, аж ахуйн хэлтэс	Барилгын эксперт
Н.Сэрчинмаа	Зээлийн газар	Зээлийн мэргэжилтэн
Б.Хонгорзул	Сувгийн удирдлагын газар	Захирал
Г.Мөнх-эрдэнэ	Нөөцийн удирдлагын газар	Дилер
Я.Эрдэнэбаатар	Байгууллагын банкны газар	Корпорэйтменежер
Г.Болормаа	Худалдааны санхүүжилтийн хэлтэс	Захирал

Голомтын соёл

Кайзен бүтээмжийн хороо

Ажилтнуудын бүтээмж, санал санаачилгыг дэмжих зорилгоор 2006 онд Үйлчилгээний чанар бүтээмжийн хороо нэртэйгээр үүсгэн байгуулагдсан Кайзен саналын системийг Голомт банк хэрэгжүүлж эхэлснээс хойш 9 дэх жилтэйгээ золгож байна.

2017 онд ажилчдаас нийт 467 санал ирж, түүнээс 280 санал үнэлэгдэж, хэрэгжих боломжтой хэмээн дүгнэгдээд байна. Үүнээс:

- Хаягдал цаасыг дахин боловсруулах /банкны харилцагч байгууллагын үйл ажиллагааг дэмжин, хаягдал цаасыг ургамлын бордоо болгон ашиглах ажилд нэгдсэн/
- Ажилтнуудын гүйлгээг хялбарчлах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилготой бүртгэлийн програмд шууд нэг товчоор гүйлгээний цэс дуудах ажил хийгдсэн.

WoW club

Голомт банкны дэргэдэх WOW /World of Writers/ клуб нь нийтлэл, блог хөтлөх сонирхолтой ажилчдыг өөрсдийн туршлага, мэдлэг, үзэл бодол, салбарын онцлогийг үгээр болон гэрэл зургаар илэрхийлэх боломж олгодог клуб юм.

Спорт хамтлаг

Голомт банкны дэргэдэх Спорт хамтлаг нь жилд дунджаар 15 орчим тэмцээн, уралдаан, спортын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, дэмжиж ажилладаг.

- Голомт банк нь жил бүр уламжлал болгон цасны баяр, 21 дэх жилдээ Адал явдалт спорт явган аяллыг зохион байгуулаад байна.



Банк хоорондын тэмцээн-2017 онд

- Банк хоорондын аварга шалгаруулах заалны хөлбөмбөгийн тэмцээнээс эрэгтэй баг алтан медаль, эмэгтэй баг мөнгөн медаль хүртсэн.
- Банк хоорондын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнээс эрэгтэй баг мөнгөн медаль хүртсэн.
- Банк хоорондын гадаа талбайн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнээс эрэгтэй баг хүрэл медаль, эмэгтэй баг мөнгөн медаль хүртсэн.
- Банк хоорондын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнээс эмэгтэй баг хүрэл медаль хүртсэн.
- Банк хоорондын аварга шалгаруулах шатрын тэмцээнд Голомт банк 6 дахь жилдээ дараалан түрүүлж, 2 дахь цомоо үүрд хадгалах эрхтэй болсон.
- Голомт банкны ажилтан Монголын 3*3 сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчин Г.Цэнгүүнбаяр азийн аварга шалгаруулах тэмцээнээс багаараа алтан медаль хүртсэн.

ЖИЛИЙН
ТАЙЛАН

2017

G-Entertainment club

Голомт банкны дэргэдэх G-Entertainment клуб нь урлаг соёлын үйл ажиллагаанд чиглэн ажилладаг бөгөөд жил бүр банкны шинэ жилийн үдэшлэг, спортын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, хамтарч ажилладаг. 2017 онд Хөгжлийн Голомт 11/11 урлагийн наадмыг зохион байгуулж, нийт 11 багийн 700 гаруй ажилтан амжилттай оролцсон.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Алсын хараа, бизнесийн зорилгод нийцсэн үр ашигтай эрсдэлийн удирдлага нь эдийн засгийн ямар ч нөхцөлд амжилттай ажиллах гол үндэс болдог төдийгүй банкны стратеги зорилтуудыг биелүүлэх хөшүүрэг мөн.



Голомт банк нь харилцагч, хадгаламж эзэмшигчид, хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг үргэлж хамгаалахаар эрсдэлийн бүхий л түвшинд хүрч ажилладаг. Үүний тулд банкны бүх шатны ажилтнууд нь эрсдэлийг ухамсарлах сэтгэлгээг төлөвшүүлж, улмаар хүчирхэг эрсдэлийн соёлыг банкны хэмжээнд бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Голомт банкны эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн хязгаарлалтуудын хүрээнд банкны ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурийг тогтвортой өсгөх, хувьсан өөрчлөгдөх бизнесийн орчинд амьдрах чадвартай эрсдэлийн хүчирхэг соёлыг түгээх голомт байхад оршино.



Эрсдэлийн аппетитын тогтолцоо

Голомт банкны эрсдэлийн аппетитын тогтолцоо нь стратеги төлөвлөгөө болон эрсдэлийн аппетитыг боловсруулах, бодит эрсдэлийн түвшин нь хязгаарлалттайгаа нийцтэй байгаа эсэхэд хяналт тавих, стратегийн үнэлгээ дүгнэлтийг стресс тестийн төсөөллүүд дээр үндэслэн хийж, шийдвэр гаргах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Эрсдэлийн аппетитын тунхаглалын хүрээнд бид зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, комплаенс эрсдэл, гэрээлэгч тал ба гуравдагч этгээдийн эрсдэл, хуулийн эрсдэл, нэр хүндийн эрсдэл, технологийн эрсдэл зэрэг үндсэн 15 төрлийн эрсдэлийн хувьд хэм хэмжээг тодорхойлсон.

Эрсдэлийн удирдлагын соёл

Голомт банкны шат шатны удирдлагууд хүчтэй эрсдэлийн соёлыг бүрдүүлэх замаар банкны ажилтан бүрийг өөрийн хариуцсан чиглэлийн дагуу эрсдэлийн удирдлагын зохих мэдлэгтэй болгосон. Улмаар удирдлагаас өгөгдсөн эрх хэмжээний дагуу өөрийн гаргасан шийдвэрт хариуцлага хүлээх, эрсдэлийн удирдлагыг банкны хэмжээнд хэрэгжүүлэн, амжилттай ажиллаж байна.

Эрсдэлийн засаглал

Голомт банк нь Гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн засаглалын бүтцийн дагуу эрсдэлийн аппетитын тогтолцоог хэрэгжүүлдэг. Ашгийн төлөө ажиллаж буй бизнесийн нэгжүүд нэгдүгээр хамгаалалтын шугам, Эрсдэлийн удирдлагын хороо ба Эрсдэлийн удирдлагын газар нь хоёрдугаар хамгаалалтын шугамыг үүсгэж, Дотоод аудитын газар гуравдугаар хамгаалалтын шугам болно.

Эхний хамгаалалт

Бизнесийн нэгжүүд

- Нэгж бүр өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийг хариуцдаг
- Аливаа шийдвэр гаргалтдаа эрсдэл өгөөжийг тооцдог
- Нэгжийн үйл ажиллагаа нь банкны эрсдэлийн удирдлагын бодлого, аппетит, журамтай нийцэж байгаа эсэхийг тогтмол хянаж, баталгаажуулдаг
- Нэгжийн KPI-д бизнес болон санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна эрсдэлийн аппетитыг хангах үзүүлэлтүүдийг тусгадаг

Хоёрдугаар хамгаалалт

Эрсдэлийн удирдлагын газар

- Эрсдэлийн удирдлагын үр ашигтай хэрэгжилтэд банкны бусад нэгжүүдээс хараат бусаар хяналт тавих
- Эрсдэлийн удирдлагын бодлого, хяналт болон эрсдэлийн хязгаарыг тодорхойлж, тайлагнах
- Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд бизнесийн нэгжүүдэд шаардлага тавих
- Банкны бодлого журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах

Гуравдугаар хамгаалалт

Дотоод аудитын газар

- Банкны үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлэх
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон хяналтын системийн зөв зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
- Аудитын хороо болон удирдлагуудад банкны үйл ажиллагааг үнэн зөв, бодитой тайлагнах

Зээлийн эрсдэлийн удирдлага

Голомт банкны хувьд зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас банк эдийн засгийн алдагдал хүлээхийг хэлнэ. Иймээс банкны зээлийн эрсдэлийн удирдлага нь ирээдүйд үүсэж болзошгүй алдагдлыг таамаглах, үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад чиглэгддэг.

Банк харилцагч төвтэй зээлийн үйл ажиллагааг бэхжүүлж, зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо олон улсын стандартад нийцсэн зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлого, журмуудыг дагаж мөрддөг. Түүнчлэн тооцоолол судалгаанд суурилсан эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлсээр байна. Үүний хүрээнд банкны түүхэн тоон мэдээлэл, зээлийн багцын чанарын үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан стресс тест хийх замаар эрсдэлийг удирдаж байна.

48

Мөн зээлийн эрсдэлийг урьдчилан илрүүлэх ажиглах жагсаалт /watchlist/, зээлийн багцын чанарын дохиологч үзүүлэлтийг боловсруулж нэвтрүүлэн ажилладаг.

2018 онд IFRS9 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, харилцагчийн зан төлөвт суурилсан зээлжих зэрэглэл болон скорингийн загвар болон зээлийн үйл ажиллагааны автоматажсан систем болох CLOS, RLOS-ийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр харилцагчийн зээлийн хүсэлтийг хүлээн авахаас олгох хүртэл бүх үе шатууд автомат болж зээлийн шийдвэрийг богино хугацаанд гаргах юм.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Голомт банкны зах зээлийн эрсдэлийн удирдлага нь хүү, валютын ханш, үнийн өөрчлөлтөөс банкны балансад болон балансын гадуур учирч болзошгүй эрсдэлийг удирдаж, ашигт ажиллагааг дэмжин ажилладаг.

Голомт банк нь дотоодын лимитүүдээ тогтмол шинэчилж, олон улс мөн Монголбанкны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилладаг. Түүнчлэн зах зээлийн гэнэтийн шок, нөхцөл байдлын стресс тестийг хийж байна.

Бид макро эдийн засгийн судалгаа, секторын судалгаа, зах зээлийн чиг хандлага, эдийн засаг болон банкны салбарын таамаглалуудыг тогтмол гаргаж ажилладаг. Үр дүнгээ олон нийтэд болон ажилчдад түгээн хүргэхээс гадна таамаглалын загваруудаа тогтмол хөгжүүлж шинэчлэн ажиллаж байна.

Хөрвөх чадвар ба хүүний эрсдэл

Бид хөрвөх чадварын эрсдэлийн хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, актив пассив хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны зөрүү болон бусад дотоод харьцаа үзүүлэлтүүдийг тооцож, хянадаг. Түүнчлэн Базель III стандартын LCR /liquidity coverage ratio/, NSFR /net stable funding ratio/ харьцаа үзүүлэлтүүдийг ханган ажиллаж байна.

Хүүний эрсдэлийн хүрээнд хүүний мэдрэмжтэй актив, пассив хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны гап тайлан, цэвэр хүүгийн ахиуц гэх мэт үзүүлэлтүүдийг тогтмол хянаж ажилладаг. Бид харилцагч талын эрсдэлийн /counterparty risk/ дагуу санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүд /дериватив/-ийн бодит үнэ цэнийн тооцоо, мөн зээлдэгч талын эрсдэлийг үнэлэн зээлдэгчийн үнэлгээний тохируулга /CVA/ хийж ажиллаж байна.

Гадаад валютын ханш, түүхий эдийн үнийн эрсдэл

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон Актив, пассивын удирдлагын хорооноос батлуулсан VaR лимитийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мөн Актив, пассивын удирдлагын хорооноос баталсан түүхий эдийн арилжааны нийт болон нэг валютын нээлттэй позицын хэмжээ, стоп-лосс лимит зэргийн тусламжтайгаар гадаад валютын ханш, түүхийн эдийн үнийн эрсдэлийг удирдаж ажилладаг.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Голомт банк нь үйл ажиллагааны эрсдэлийг дотоод үйл ажиллагаа болон системийн хангалтгүй байдал, хүний хүчин зүйл болон гадаад орчны таагүй нөлөөллөөс үүдэн үүсэх хохирол гэж тодорхойлдог.

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын асуудлууд Гүйцэтгэх удирдлагын Эрсдэлийн хороогоор шийдвэрлэгддэг бөгөөд I болон II хамгаалалтын шугам нь тус шийдвэрийн дагуу эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэн ажилладаг.

Бид үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын шилдэг туршлагуудыг амжилттай нэвтрүүлэн, жилээс жилд хөгжүүлэн ажиллаж байна. Үүнээс онцолбол:

- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг 3 давхар хамгаалалтын шугамын дагуу хэрэгжүүлж дотоод хяналтын тогтолцоог сайжруулах замаар аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, үүсч болзошгүй болон үүссэн эрсдэлийг оновчтой, үр дүнтэйгээр удирдан ажилладаг.
- Эрсдэлийн өөрийн үнэлгээний аргыг ашиглан бүх газар нэгжүүд эрсдэлийн удирдлагыг шат шатандаа хэрэгжүүлдэг.
- Банкны бүх процессыг хамарсан Key risk indicators буюу эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг ашиглан бүрэн хэмжээнд хяналт тавьж ажилладаг.
- Базелийн хорооноос санал болгодог Advanced measurement approach аргачлалыг ашиглан эрсдэлийн түүхэн мэдээлэлд тулгуурлан тухайн жилд хүлээгдэж буй үйл ажиллагааны эрсдэлийн хэмжээг тооцож, тус тооцоололд тулгуурлан хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагааны эрсдэлийн хэмжээгээр сан байгуулан ажилладаг.

Мөн харилцагчдадаа чиглэсэн тэднийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой санхүүгийн луйвар, кибер халдлагын талаарх сургалтуудыг зохион байгуулж, аюулгүй байдлын зөвлөмж, анхааруулгуудыг тогтмол хүргэж ажилладаг. 2018 онд тус үйл ажиллагааг улам бүр өргөжүүлж, банкны харилцагч болон харилцагч бус нийт иргэдэд хүргэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тусгай хяналтын программыг нэвтрүүлэв

Голомт банк нь өөрийн Комплаенсийн дотоод хяналтын тогтолцоог улам сайжруулан бэхжүүлэх зорилгоор мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх AMLOCK®-FCDMS тусгай хяналтын бүрэн автоматжсан программ нэвтрүүлсэн. Уг программ нь сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх, харилцагчийг хориг арга хэмжээний жагсаалттай тулган шалгах, харилцагчийн эрсдэлийн үнэлгээг хийх зэрэг үйлдлүүдийг автоматаар гүйцэтгэх бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй юм.

КОМПЛАЕНСИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Голомт банкны Комплаенсийн хэлтэс нь бизнесийн нэгжүүдээс ангид, бие даасан статустай, Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор ажилладаг, комплаенсийн эрсдэлүүдийг үр дүнтэй удирдах чиг үүрэг бүхий нэгж юм.

Комплаенсийн онцлох үйл явдлууд

Комплаенсийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулж, бэхжүүлэх зорилгоор мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх AMLOCK®-FCDMS тусгай хяналтын бүрэн автоматжилсан программ болон мөнгө угаах терроризмын санхүүжилттэй тэмцэх тусгай хяналтын программыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээд байна.

Комплаенсийн соёл

Голомт банк дотоодын зах зээлд комплаенсийн хэрэгжилтээрээ тэргүүлэгч нь болох эрхэм зорилгынхоо хүрээнд:

- Комплаенсийн бодлого
- Зөрчлийг мэдээлэх бодлого
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам
- Авлигын эсрэг үйл ажиллагааны журам
- Комплаенсийн эрсдэлийн үнэлгээний аргачлал зэрэг чухал ач холбогдол бүхий бичиг баримтуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн батлуулсан.

Банкны комплаенс хариуцсан ажилтнууд CAMS® (certified AML Specialist буюу Мөнгө угаахтай тэмцэх мэргэжилтэн), CCEP-I® (Certified Compliance and Ethics Professional буюу Комплаенс болон Ёс зүйн мэргэжилтэн) хэмээх нэр хүнд бүхий цол хэргэм хүртэж, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд болоод байна.



Актив, пассивын УДИРДЛАГА

Монголд анх удаа актив, пассивын хосолсон удирдлагыг нэвтрүүлж, хосолмол, харилцан уялдаатай удирдлагыг хэрэгжүүлэх, оновчтой бөгөөд шуурхай хариу үйлдэл үзүүлэх, ирээдүйн ашигт ажиллагааг тогтмол хангахуйц шийдвэрийг гаргах үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

Оновчтой балансын бүтцийн тод жишээ нь нийт активт эзлэх гадаад валютын зээл өсөж, татан төвлөрүүлсэн гадаад валютын эх үүсвэр буурсан юм. Ингэснээр гадаад валютын цэвэр хүүний ахиуц өмнөх жилүүдээс огцом өссөн.

2017 онд Монголбанк бодлогын хүүг бууруулснаар банк хоорондын захын хүү буурсан байна.

Бодлогын хүү:


2015 онд **13%** | **2016** онд **14%** | **2017** онд **11%**

Зах зээлийн энэхүү өөрчлөлтөд Актив, пассивын хороо хуралдаж бодлого, шийдвэрүүдийг гаргаснаар эх үүсвэрийн зардлыг бууруулж, цэвэр хүүний ахиуцыг 3 хувиас 3.3 хувь болгоод байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт удааширсан тайлант жилүүдэд Голомт банк нь төлбөр түргэн

гүйцэтгэх чадварыг хангалттай түвшинд хадгалахад анхаарал хандуулсаар ирсэн. Гадаад валютын хөрвөх чадварын харьцааг бууруулж, төгрөгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлснээр 2017 оны эцэст банкны хөрвөх чадвар 45 хувь болсон.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар > 25%



Монголбанкны шаардлагыг ханган

ажиллахын сацуу Базелийн хорооны хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд болох LCR (30 хоногийн хөрвөх чадвар), NSFR (1 жилийн тогтвортой эх үүсвэр)-н үзүүлэлтүүдийг дотоод удирдлагын хүрээнд тооцож ажилласан бөгөөд тогтмол 100 хувиас дээш хангаж ажиллалаа.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, төв банкны бодлогын хүү болон банк хоорондын захын хүү нь банкинд бага зардлаар санхүүжилт татах боломжийг олгосноос гадна актив, пассивын удирдлагын хүрээнд төв банкт урт хугацаат своп хэлцлийг амжилттай хийгээд байна. Харин гадаад валютын удирдлагын хувьд валютын оновчтой нөөцийг бий болгон гадаад валютын зээлийг нэмэгдүүлсэн.

Урт хугацааны актив, пассивын төлөвлөгөөг боловсруулж, бүтээгдэхүүний үнэ тогтоох, хөрвөх чадвар, балансын цогц шийдэл болсон Fund Transfer Pricing аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласан. Энэхүү аргачлалаар дамжуулан оновчтой балансын бүтэц, бага өртөгтэй эх үүсвэр, шударга үнэлгээний системийг бий болгосон нь томоохон амжилт юм.



Компанийн ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хороо ба тайлант хугацаанд Компаенсийн бодлого, Зээлийн бодлогыг сайжруулж зээлийн эрсдэлийн хязгаарыг шинэчлэн ажилласан.

2017 онд тус хороо нь нийт 11 удаа хуралдаж 30 асуудал хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.

Засаглал, Ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь банкны хүний нөөц, цалин урамшууллын бодлогыг чиглүүлэхээс гадна ёс зүй, засаглалын асуудлыг эрхэлдэг. Тус хороо нь ТУЗ болон Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг боловсруулсан загварын дагуу үнэлдэг ба Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн гүйцэтгэлд зөвлөж оролцдог. 2017 онд тус хороо нь 4 удаа ээлжит хурал хийж нийт 10 асуудал хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2017

Аудитын хороо

Голомт банкны Аудитын хороо нь 2017.01-2017.06 сарыг дуустал 5 гишүүнтэй /2 хараат бус гишүүн/, 2017.07-2017.12 сарыг дуустал 4 гишүүнтэй /2 хараат бус гишүүн/ ажилласан байна. Хараат бус гишүүн Ж.Үнэнбат нь Аудитын хорооны даргаар 2017 оны 7 сараас хойш ажиллаж байна.

Үндсэн чиг үүрэг

- Санхүүгийн тайлантай холбоотой
- Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой
- Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Тайлагналын үйл ажиллагаатай холбоотой
- Бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг удирддаг.

2017 онд хэлэлцсэн асуудлууд

Аудитын хороо нь 2017 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 13 удаа хуралдан, 60 асуудлыг хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.



Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байна.

Аудитын хороо нь Дотоод аудитын газрын эрх, үүргийг тусгасан дүрэм, үйл ажиллагааны журам, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлдэг. Мөн дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, үйл ажиллагаандаа олон улсын стандарт, арга аргачлалыг ашиглаж буй эсэх болон аудитын тайлан, тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянадаг. Аудитын хороо нь Аудит хариуцсан захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д хүргүүлж, ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг тогтоодог.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг

Хатагтай Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3-р бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс хопкинсийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад мэргэжил дээшлүүлсэн. 1996 онд ажлын гараагаа Монголын хөрөнгийн биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан, Nepco хэвлэлийн компани зэрэг газруудад ажиллаж байсан. 2010 оноос Тойм сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан бөгөөд 2012 оны 12 сард Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12 сард Голомт банкны ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн Урс Э.Шварценбах

Ноён Урс.Э.Шварценбах нь Швейцарь улсын Зюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Зюрих, 1972 онд Лондон дахь Юнион банкинд ажилласан. 1976 оноос өөрийн бизнесийг эхэлсэн бөгөөд 2000 онд Канадын Номв Скотиагийн Сант Францисийн Зевиер их сургуулийн Хүндэт доктор цолоор шагнагдсан. Ноён Урс.Э.Шварценбах нь 2010 оны 1 сараас Швейцарь улсад амьдарч байгаа ХБНГУ-ын иргэдийг төлөөлөн Монгол Улсын хүндэт консулаар өргөмжлөгдсөн. Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр 2011 оноос эхлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр

Ноён Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн ЭЗС-ийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн. 1996 оноос Голомт банкинд туслах ажилтнаас эхлэн эдийн засагч, зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, Тэргүүн дэд захирлын үүрэгт ажлыг хашиж байсан. 2012 онд ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Үнэнбат

56

Ноён Ж.Үнэнбат нь 1985 онд ОХУ-ын Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжлээр төгссөн. 1994 онд АНУ-ын Колумбын Их сургуульд олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, Дэд профессор цолтой. 1990 оноос Монголбанкинд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996–2000 онд Монголбанкны Ерөнхийлөгч, 2000–2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн гүйцэтгэх захирлаар ажиллаж ирсэн. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийсэн, банк санхүүгийн чиглэлээр арвин их туршлага хуримтлуулсан нэгэн юм.


ТУЗ-ийн хараат бус гишүүн Антонио Л.Абелло


Ноён Антонио Л.Абелло нь Испанийн Барселеоны их сургуулийг хуульч мэргэжлээр, IESE бизнесийн сургуулийг бизнесийн удирдлагын магистр цолтойгоор төгссөн. Барселеоны хуулийн Ассоциацийн мэргэшсэн хуульч, CEFFAS стандартын дагуу Мэргэшсэн санхүүгийн судлаач (CFA) зэрэгтэй. Кредит Свисс, Голдмэн Сакс болон Парибас банкуудад бонд болон хөрөнгийн санхүүжилт хариуцсан удирдах түвшний албан тушаалуудыг хашиж байсан. Сингапур болон Лондон хотын хөрөнгө оруулалтын тэргүүлэгч банкуудад 20 гаруй жил ажилласан, олон улсад өндрөөр үнэлэгддэг туршлагатай банкируудын нэг юм. Тэрбээр Turms Advisors LLP фирмийг үүсгэн байгуулагч, партнераар ажилладаг. 2014 онд Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б.Двайер

Ноён Двайер нь Нотр Дам их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн ба мэргэшсэн санхүүгийн шинжээч юм. Тэрээр 1970 оноос хойш UBS банкны Компанийн нэгдэл, компани худалдан авах процесс хариуцсан захирал зэрэг Нью-Йоркийн Wallstreet-д байрлалтай санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын банкир хийж байсан туршлагатай. Ноён Двайер 2001 онд Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын ажиллагаанд оролцохоор Монголд анх хөл тавьж, Хойд Америкийн бизнес зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2007 онд Монголын бизнесийн зөвлөлийг үүсгэн байгуулсан. Тэрээр Мандал даатгал болон Mongolia Growth Group ХХК-иудад ТУЗ-ийн хараат бус гишүүн, Mongoljin private capital-ийн Гүйцэтгэх бус ТУЗ-ийн дэд дарга, Монголын боловсролын сангийн ТУЗ-ийн дарга, Ерөнхийлөгчийн албыг хашдаг.

ГОЛОМТ БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





ДОТООД АУДИТ

Дотоод аудитын үйл ажиллагаа нь аудит хийж буй үйл ажиллагаанаасаа хараат бус байх бөгөөд үйл ажиллагааны зорилт, эрх, үүргийн хамрах хүрээ нь ТУЗ-өөр батлагдсан Дотоод аудитын газрын дүрэмд тусгагдсан байна. Дотоод аудитын газар нь ТУЗ, Аудитын хороонд ажлаа тайлагнах бөгөөд аудитлагдсан нэгж, үйл ажиллагаатай холбоотой тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлнэ.

Үндсэн чиг үүрэг

- Банк болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа хууль, эрх зүйн актын дагуу явагдаж байгаа эсэх
- Зохистой удирдлага, нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлан үнэн зөв эсэхэд бодит баталгаажуулалт хийх
- Дотоод хяналтын тогтолцоо болон эрсдэлийн удирдлага тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх
- Банкны гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс баталсан бодлого болон дүрэм, тогтоол, шийдвэрүүдийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих
- Гүйцэтгэх удирдлагаас гаргасан шийдвэрүүд эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үндэслэдэг эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх

Дотоод аудитын газар нь 2018 онд стратегид суурилсан аудит болон эжайл аудитын аргачлалыг хөгжүүлэхээр зорьж байна.

Дотоод аудитын газар нь эрсдэлийн үнэлгээг хийхдээ Дотоод аудиторчуудын институт (IIA Global)-ын санал болгож буй аргачлалуудаас Тусгайлсан эрсдэлийн үнэлгээний загварыг сонгож, 3+9 зарчим буюу эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийх, уг үнэлгээнд үндэслэж аудитын төлөвлөгөө улирал бүр өөрчлөгдөх боломжтой байх зарчмыг баримталдаг.



ГОЛОМТ БАНК ГРУПП

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу
бэлтгэгдсэн Санхүүгийн тайлангууд болон Хараат бус
аудиторын тайлан

2017 оны 12 дугаар сарын 31



Хараат бус аудиторын тайлан

Голомт банк ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа Эзэмшигчдэд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Голомт банк ХХК ("Банк" гэх) болон түүний салбар компани болох Голомт Капитал ХХК (хамтад нь "Групп")-ийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Банкны тусдаа санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн болон тусдаа мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон Банкны тусдаа санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн байдлын тайлан,
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй, бусад тайлбар болон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудын тодруулга

Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн *Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Группээс бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Онцлох асуудал

Бид 2017 онд Монголбанкны ("МБ") хүсэлтийн дагуу Монгол улсын банкны салбарт хийгдсэн Активын Чанарын Үнэлгээ ("АЧҮ")-г багтаасан Монголын улсын арилжааны банкуудын Төлбөрийн Чадварын Үнэлгээний талаар тодруулсан тус санхүүгийн тайлангуудын Тодруулга 39-д анхаарлыг тань хандуулж байна. Монгол банкны зүгээс эдгээр санхүүгийн тайлангуудын батлагдсан өдрийн байдлаар АЧҮ-ний явцыг хараахан эцэслэсэн гэж зарлаагүй буюу Банкны хувьд төдийгүй Монголын санхүүгийн салбарийн хувьд үнэлгээний боломжит үр дагавар нь тодорхойгүй болон тодорхойлох боломжгүй байдалтай холбоотой. Энэ асуудлын хүрээнд бидний дүгнэлт хязгаарлагдаагүй болно.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Группийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Группийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Группийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн болон санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)


АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Групп нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Группийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.
- Тодруулгуудыг оролцуулан нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргахын тулд Группийн доторх байгууллагууд эсвэл бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй хамааралтай аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид групп аудитыг гүйцэтгэх болон нягтлан шалгах чиглэлээр хариуцлага хүлээдэг. Бид зөвхөн гаргасан аудитын дүгнэлтэндээ хариуцлага хүлээнэ.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.



Гарын үсэг зурсан:



Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Мэттью Поттл
Партнер
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Улаанбаатар, Монгол Улс
2018 оны 3 сарын 30

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп		Банк	
		2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Төв Банкнд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)	7	222,779,111	317,585,827	222,351,578	316,801,192
Монголбанкнд байршуулсан зайлшгүй байлгах нөөц	8	395,029,289	315,633,095	395,029,289	315,633,095
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	9	250,270,731	395,641,113	249,076,344	395,422,594
Урвуу репо хэлцэл	10	-	9,995,766	-	9,995,766
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	11	592,304,403	792,154,555	592,304,403	792,154,555
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	12	2,318,058,202	2,034,859,755	2,318,058,202	2,034,859,755
Богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас	13	632,003,148	41,979,911	632,003,148	41,979,911
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас	14	218,616,988	126,165,928	218,616,988	126,165,928
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас	15	145,539,393	121,553,766	144,822,457	120,274,349
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	16	57,505,587	51,291,334	57,505,587	51,291,334
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	17	-	-	1,200,000	1,200,000
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	40	75,466,402	177,021,621	75,466,402	177,021,621
Бусад хөрөнгө	18	43,861,887	28,381,165	44,330,748	28,333,835
Биет бус хөрөнгө	19	13,616,834	13,948,312	13,616,825	13,946,737
Үндсэн хөрөнгө	20	140,594,973	171,022,155	140,555,122	171,008,642
Өмчлөх бусад хөрөнгө	21	47,090,786	44,809,609	47,090,786	44,809,609
Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө	22	52,556,417	17,444,424	52,556,417	17,444,424
Нийт хөрөнгө		5,205,294,151	4,659,488,336	5,204,584,296	4,658,343,347
Өр төлбөр					
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	23	388,192,233	121,902,017	388,192,233	121,902,017
Харилцагчдын харилцах, хадгаламж	24	3,454,091,632	2,803,875,469	3,453,919,747	2,803,327,560
Зээлийн бусад эх үүсвэр	25	757,897,323	1,195,869,997	757,897,323	1,195,869,997
Репо хэлцэл	26	47,343,007	37,408,551	47,343,007	37,408,551
Орлогын татварын өглөг	34	6,035,111	-	6,035,111	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	34	9,549,724	10,678,082	9,551,071	10,679,318
Зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн сан	39	673,275	793,072	673,275	793,072
Бусад өр төлбөр	27	52,394,296	34,093,768	52,240,676	34,055,598
Хоёрдогч өглөг	28	97,042,814	87,733,803	97,042,814	87,733,803
Нийт өр төлбөр		4,813,219,415	4,292,354,759	4,812,895,257	4,291,769,916
Эзэмшигчдийн өмч					
Давуу эрхтэй хувьцаа	29	25,778,900	25,778,900	25,778,900	25,778,900
Хувьцаат капитал	29	26,367,593	26,367,593	26,367,593	26,367,593
Нэмэгдэж төлөгдсөн капитал		46,583,557	46,583,557	46,583,557	46,583,557
Хуримтлагдсан ашиг		218,919,388	240,998,876	218,533,691	240,438,730
Өмчийн бусад хэсэг		74,425,298	27,404,651	74,425,298	27,404,651
Нийт эзэмшигчдийн өмч		392,074,736	367,133,577	391,689,039	366,573,431
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		5,205,294,151	4,659,488,336	5,204,584,296	4,658,343,347

2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Банкны Удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.



Ч.МӨНХЦЭЦЭГ
ТУЗ-ийн дарга



Ө.ГАНЗОРИГ
Гүйцэтгэх захирал



М.ЧИМЭГМӨНХ
Санхүүгийн удирдлагын газрын захирал

Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп		Банк	
		2017	2016	2017	2016
Хүүгийн орлого	30	409,493,040	332,107,188	409,219,855	331,899,510
Хүүгийн зардал	30	(287,227,650)	(246,411,088)	(287,229,507)	(246,415,535)
Хүүгийн цэвэр орлого		122,265,390	85,696,100	121,990,348	85,483,975
Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	12	(33,411,559)	(51,903,798)	(33,411,559)	(51,903,798)
Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого		88,853,831	33,792,302	88,578,789	33,580,177
Хураамж, шимтгэлийн орлого	31	36,693,542	28,441,027	35,650,124	27,982,366
Хураамж, шимтгэлийн зардал	31	(10,174,186)	(7,699,015)	(9,808,785)	(7,608,826)
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз	9	3,381,623	966,643	3,370,866	960,857
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн (гарз)/олз	40	(65,296,303)	136,753,014	(65,296,303)	136,753,014
Гадаад валют болон үнэт металын арилжаанаас үүссэн олз		16,979,721	15,124,620	16,979,721	15,124,620
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас борлуулснаас үүссэн олз		1,877,287	-	1,877,287	-
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз/ (гарз)		21,027,625	(111,669,509)	21,033,400	(111,710,252)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	18	(167,175)	(3,646,340)	(167,175)	(3,644,340)
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралтын зардал		(20,157,623)	-	(20,157,623)	-
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	21	286,172	(2,345,199)	286,172	(2,345,199)
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардал		119,797	(793,072)	119,797	(793,072)
Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал		(3,774,036)	-	(3,774,036)	-
Ногдол ашгийн орлого		2,729,968	306,444	3,290,112	306,444
Үйл ажиллагааны бусад орлого	32	1,531,384	1,397,036	1,518,163	1,391,723
Удирдлага болон үйл ажиллагааны бусад зардал	33	(86,150,129)	(77,568,743)	(85,583,444)	(77,251,293)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		(12,238,502)	13,059,208	(12,082,935)	12,746,219
Орлогын албан татварын кредит/(зардал)	34	6,911,199	(7,471,460)	6,930,081	(7,472,658)
Тайлант жилийн ашиг/(алдагдал)		(5,327,303)	5,587,748	(5,152,854)	5,273,561
Бусад дэлгэрэнгүй орлого:					
Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдаж болзошгүй зүйлс:					
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт:					
- Тухайн жилийн цэвэр олз		47,347,785	534,662	47,347,785	534,662
Шууд дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн татварын зардал		(11,836,946)	(295,339)	(11,836,946)	(295,339)
Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдахгүй зүйлс:					
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		(5,242,377)	2,738,497	(5,242,377)	2,738,497
Тайлант жилийн нийт бусад дэлгэрэнгүй (зардал)/орлого	35	30,268,462	2,977,820	30,268,462	2,977,820
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		24,941,159	8,565,568	25,115,608	8,251,381

Голомт Банк Групп

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Группын эзэд хамаарах							
		Давуу эрхтэй хувьцаа	Хувьцаат капитал	Нэмэгдэж төлөгдсөн капитал	ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	Барилгын дахин үнэлгээний нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Эзэмшигчдийн өмчийн нийт дүн
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	4,581,064	7,476,100	-	247,780,795	358,568,009
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	5,587,748	5,587,748
Бусад дэлгэрэнгүй орлого	35	-	-	-	239,323	2,738,497	-	-	2,977,820
2016 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	239,323	2,738,497	-	5,587,748	8,565,568
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	36	-	-	-	-	(569,729)	-	569,729	-
МБ-ны журмын дагуу бусад нөөцрүү шилжүүлсэн хуримтлагдсан ашгийн хэсэг (Тодруулга 12)		-	-	-	-	-	12,581,184	(12,581,184)	-
Тусгай зориулалтын нөөц рүү шилжүүлсэн хуримтлагдсан ашгийн хэсэг	4,27	-	-	-	-	-	358,212	(358,212)	-
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	4,820,387	9,644,868	12,939,396	240,998,876	367,133,577
Тухайн жилийн алдагдал		-	-	-	-	-	-	(5,327,303)	(5,327,303)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	35,510,839	(5,242,377)	-	-	30,268,462
2017 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	35,510,839	(5,242,377)	-	(5,327,303)	24,941,159
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	(440,582)	-	440,582	-
МБ-ны журмын дагуу бусад нөөцрүү шилжүүлсэн хуримтлагдсан ашгийн хэсэг (Тодруулга 12 ба 21)		-	-	-	-	-	17,192,767	(17,192,767)	-
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	40,331,226	3,961,909	30,132,163	218,919,388	392,074,736

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

Банкны эздэд хамаарах									
Мянган төгрөгөөр	Тодруулга	Давуу эрхтэй хувьцаа	Хувьцаат капитал	Нэмэгдэж төлөгдсөн капитал	ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	Барилгын дахин үнэлгээний нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Эзэмшигчдийн өмчийн нийт дүн
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	4,581,064	7,476,100	-	247,534,836	358,322,050
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	5,273,561	5,273,561
Бусад дэлгэрэнгүй орлого	35	-	-	-	239,323	2,738,497	-	-	2,977,820
2016 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	239,323	2,738,497	-	5,273,561	8,251,381
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	(569,729)	-	569,729	-
МБ-ны журмын дагуу бусад нөөцрүү шилжүүлсэн хуримтлагдсан ашгийн хэсэг (Тодруулга 12)		-	-	-	-	-	12,581,184	(12,581,184)	-
Тусгай зориулалтын нөөцрүү шилжүүлсэн хуримтлагдсан ашгийн хэсэг	4,27	-	-	-	-	-	358,212	(358,212)	-
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	4,820,387	9,644,868	12,939,396	240,438,730	366,573,431
Тухайн жилийн алдагдал		-	-	-	-	-	-	(5,152,854)	(5,152,854)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	35,510,839	(5,242,377)	-	-	30,268,462
2017 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	35,510,839	(5,242,377)	-	(5,152,854)	25,115,608
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	(440,582)	-	440,582	-
МБ-ны журмын дагуу бусад нөөцрүү шилжүүлсэн хуримтлагдсан ашгийн хэсэг (Тодруулга 12 ба 21)		-	-	-	-	-	17,192,767	(17,192,767)	-
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	40,331,226	3,961,909	30,132,163	218,533,691	391,689,039

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп		Банк	
		2017	2016	2017	2016
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Татварын өмнөх ашиг/ (алдагдал)		(12,238,502)	13,059,208	(12,082,935)	12,746,219
Тохируулгууд:					
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны үнэ цэнийн бууралт	12	33,411,559	51,903,798	33,411,559	51,903,798
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз		(3,370,868)	(963,187)	(3,370,866)	(960,857)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн гарз /(олз)		65,296,303	(136,753,014)	65,296,303	(136,753,014)
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны борлуулалтаас үүссэн олз	9,40	(1,877,287)	-	(1,877,287)	-
Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг		(12,751)	-	(12,751)	-
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр ашиг/алдагдал		(21,027,625)	111,667,665	(21,033,400)	111,710,252
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт	18	167,175	3,646,340	167,175	3,644,340
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		20,157,623		20,157,623	
Аккредитив, баталгааны үнэ цэнийн бууралтын сангийн орлого (зардал)		(119,797)	793,072	(119,797)	793,072
Борлуулахад бэлэн эргэлтийн бус хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал		3,774,036	-	3,774,036	
Элэгдлийн зардал	20	8,774,386	9,665,371	8,762,817	9,661,969
Хорогдуулалтын зардал	19	1,621,165	2,849,105	1,619,599	2,845,311
Данснаас хассан үндсэн хөрөнгө	20	58,103	(244,481)	58,703	(244,481)
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн өсөлт/ (бууралт)	21	(286,172)	2,345,199	(286,172)	2,345,200
Мөнгөн бусаар хүлээн авсан ногдол ашиг		(2,763,321)	-	(2,763,321)	-
Хүүгийн орлого	30	(409,493,040)	(332,111,635)	(409,219,855)	(331,899,510)
Хүүгийн зардал	30	287,229,507	246,415,535	287,229,507	246,415,535
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		(30,699,506)	(27,727,024)	(30,289,062)	(27,792,167)
Монголбанкинд байршуулсан, зайлшгүй байлгах нөөцийн цэвэр бууралт/ (өсөлт)					
		(79,396,194)	(54,893,683)	(79,396,194)	(54,893,683)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр бууралт /(өсөлт)					
		181,338,414	59,837,125	181,338,414	59,837,126
Арилжааны үнэт цаасны цэвэр бууралт/(өсөлт)					
		44,728,636	(251,409,930)	44,728,636	(251,409,930)
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны бууралт/(өсөлт)					
		(503,031,996)	(32,946,006)	(503,031,996)	(32,946,006)
Бусад хөрөнгийн цэвэр өсөлт					
		(15,480,724)	(6,671,097)	(15,748,710)	(6,524,386)
Өмчлөх бусад хөрөнгийн өсөлт					
		(6,335,430)	(67,526,708)	(6,335,430)	(67,526,708)
Борлуулахад бэлэн эргэлтийн бус хөрөнгийн цэвэр бууралт					
		15,853,154	-	15,853,154	-
Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн цэвэр өсөлт					
		263,016,245	21,570,424	263,016,245	21,570,424
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт					
		633,843,485	471,832,917	634,219,508	471,259,423
Бусад санхүүгийн өр төлбөрийн цэвэр өсөлт					
		18,282,675	18,644,376	18,185,078	18,664,628
Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагаанаас олсон/ (үйл ажиллагаанд зарцуулсан) цэвэр мөнгө					
		522,118,759	130,710,394	522,539,643	130,238,722
Төлсөн орлогын албан татвар					
		6,904,038	(2,014,343)	6,930,081	(2,014,312)
Хүлээн авсан хүү					
		421,305,911	265,927,495	421,086,080	265,715,369
Төлсөн хүү					
		(267,399,930)	(243,138,932)	(267,399,930)	(243,138,932)
Үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгө		682,928,778	151,484,614	683,155,874	150,800,847

Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп		Банк	
		2017	2016	2017	2016
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ					
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны худалдан авалт		(661,083)	(82,206)	(661,083)	(82,206)
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас борлуулсаны орлого		4,838,732	8,715	4,838,732	8,715
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаасны худалдан авалт		(13,611,100)	-	(13,611,100)	-
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас эргэн худалдсаны орлого		3,880,810	59,488,900	3,880,810	59,488,900
Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(17,018,106)	(5,093,775)	(16,980,199)	(5,091,827)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	20	5,423,729	3,453,211	5,423,729	3,453,211
Биет бус хөрөнгийн худалдан авалт	19	(1,289,688)	(2,056,837)	(1,289,688)	(2,056,049)
Хөрөнгө оруулалтад зарцуулсан цэвэр мөнгө		(18,436,706)	55,718,008	(18,398,799)	55,720,744
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Рено хэлцлээс хүлээн авсан		793,407,576	610,385,555	793,407,576	610,385,555
Рено хэлцлийн эргэн төлөлт		(783,473,121)	(747,335,984)	(783,473,121)	(747,335,984)
Зээлийн бусад эх үүсвэрээс хүлээж авсан	36	40,649,559	268,144,839	40,649,559	268,144,839
Зээлийн бусад эх үүсвэрийн эргэн төлөлт	36	(395,493,939)	(156,480,679)	(395,493,939)	(156,480,679)
Хоёрдогч өглөгөөс хүлээж авсан	28	12,000,000	-	12,000,000	-
Хоёрдогч өглөгийн эргэн төлөлт	36	(848,467)	-	(848,467)	-
Санхүүгийн үйл ажиллагаанд (зарцуулсан)/орсон мөнгөн гүйлгээ		(333,758,392)	(25,286,269)	(333,758,392)	(25,286,269)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлт		4,602,426	(108,758,256)	4,694,525	(108,800,631)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		335,336,106	73,154,324	335,693,208	72,434,691
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		805,403,936	732,249,612	804,619,301	732,184,610
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	1,140,740,043	805,403,936	1,140,312,509	804,619,301

Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө шаардагдаагүй МИК-ТЗК-ийн хэлцлүүд нь Мөнгөн гүйлгээний тайланд ороогүй бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 3 болон 15-аас үзнэ үү.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанаас өмчлөх бусад хөрөнгө рүү, өмчлөх бусад хөрөнгөөс борлуулахад бэлэн эргэлтийн бус хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалтай үл хөдлөх хөрөнгө рүү шилжсэн мөнгөн бус гүйлгээ нь мөнгөн гүйлгээний тайланд ороогүй бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 4.32, 16, 21 болон 22-оос үзнэ үү.

7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	111,872,603	101,879,822	111,445,070	101,095,187
Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад)	110,906,508	215,706,005	110,906,508	215,706,005
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	222,779,111	317,585,827	222,351,578	316,801,192

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгө нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулагдахгүй. 2017 оны 12 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус хөрөнгийн дүнд хугацаа хэтэрч, эсвэл үнэ цэнэ буурсан дүн байхгүй. Монголбанк нь Мүүди-с-ийн Саа1 үнэлгээтэй.

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгийн валют, хүү болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 37-с үзнэ үү.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан хөрөнгө (Тодруулга 7)	222,779,111	317,585,827	222,351,578	316,801,192
Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө (Тодруулга 11)	285,957,783	294,216,826	285,957,783	294,216,826
Монголбанкны үнэт цаас (Тодруулга 13, 15)	632,003,148	41,979,911	632,003,148	41,979,911
Засгийн Газрын бонд (Тодруулга 9)	-	141,625,606	-	141,625,606
Урвуу репо хэлцэл (Тодруулга 10)	-	9,995,766	-	9,995,766
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,140,740,042	805,403,936	1,140,312,509	804,619,301

8. Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	395,029,289	315,633,095
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	395,029,289	315,633,095

Банк нь Төв Банк буюу Монголбанкн дахь харилцах дансандаа Монголбанкнаас тавьдаг шаардлагын дагуу зайлшгүй байлгах нөөц байршуулдаг. Төв Банкн дахь байршуулдаг хөрөнгийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12.0% (2016: 12.0 %) -аас багагүй байдаг. Группийн болон Банкны заавал байлгах нөөцийн дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2017 оны 12 дугаар сарын 31

9. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хөрөнгө нь анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн засгийн газрын бонд болон Хонг Конг, Торонто болон Нью Йоркийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй арилжаалагддаг өмчөөрх хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

2017 оны 12 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгүүдийг доор харуулав:

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Засгийн Газрын бонд	235,688,212	246,843,505	234,686,513	246,643,506
Өмчлөх бусад хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн оронд хураагдсан барьцаа хөрөнгө болох үл хөдлөх болон санхүүгийн хөрөнгүүдийг илэрхийлнэ. Банкны зүгээс эдгээр хөрөнгийг ойрын хугацаанд зарж борлуулах төлөвлөгөөтэй байгаа. Эдгээр үл хөдлөх хөрөнгө нь худалдахад бэлэн эргэлтийн бус хөрөнгийн шаардлагыг хангаагүй бөгөөд НББОУС 2 “Бараа материал”-ын дагуу бараа материалд ангилагдсан.

21. Өмчлөх бусад хөрөнгө

Үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгийн хэлбэрээр түр хугацаагаар авсан барьцаа хөрөнгийг СТОУС-ын хэмжилтийн зорилгоор тэдгээрийг борлуулахад бэлэн үнэт цаас гэж ангилж, бодит үнэ цэнээр нь хэмждэг. Эдгээр хөрөнгийг анхны бодит үнээс нь бичилтийг зөвшөөрсөн болно.

Групп 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд удирдлагын шийдвэрийн дагуу 5,987,801 мянган төгрөгийн (2016 онд: 50,082,284 мянган төгрөг) өмчлөх бусад хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө ангилалруу, 37,302,020 мянган төгрөгийн (2016 онд: 17,444,424 мянган төгрөг) өмчлөх бусад хөрөнгийг борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө ангилал руу тус тус ангилсан. Тодруулга 16, 22-ыг харна уу.

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө нь Банкны хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах явцад авсан Бурхан Дэл Алт ХХК-ийн хувьцааг илэрхийлнэ. Уг санхүүгийн өмчлөх бусад хөрөнгө нь борлуулахад бэлэн үнэт цаасаар бүртгэсэн. Тодруулга 42-ыг харна уу.

Өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бус хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн үүргийг хангуулахаар хураан авсан буюу түүний борлуулалтаас зээлийг эргэн төлүүлэхээр зорилготой юм. Дээрх үнэ цэнэ бууралтын сан нь зөвхөн санхүүгийн бус хөрөнгөтэй холбоотой. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар тодруулга 4.33-аас үзнэ үү.

Санхүүгийн бус хураан авсан барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санд 2017 болон 2016 онд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2017	2016
01 сарын 01-нээрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	4,101,061	1,755,861
Тухайн жилд байгуулсан үнэ цэнэ бууралтын сан	(286,172)	2,345,200
Төлөгдөхгүй гэж үзээд данснаас хассан	(1,413,673)	-
12 сарын 31-нээрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	2,401,216	4,101,061

Монголбанкны журмын дагуу байгуулсан үнэ цэнийн бууралтын сан нь СТОУС-ын дагуу байгуулсан үнэ цэнийн бууралтын нөөц сангаас илүү байсан тул Тодруулга 12-д тодруулсаны дагуу 29,773,951 мянган төгрөгийн нөөц бүртгэсэн.

Дээрх дүн нь Группийн болон Банкны дүнг илэрхийлж буй тул тусдаа тодруулга шаардлагагүй.

22. Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө

Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгөд өмнө нь хугацаа хэтэрсэн зээлийн үүргийг хангуулахаар хураан авсан өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй байсан үл хөдлөх хөрөнгүүд багтана. Удирдлагын зүгээс 2017 оны 12 дугаар 07-ны өдөр эдгээр эргэлтийн бус хөрөнгийг худалдах төлөвлөгөөг баталсан. Групп худалдан авагчийг олох ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж буй бөгөөд тайлант хугацаанаас 12 сарын дотор худалдахаар таамаглаж буй. Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар дэлгэрэнгүйг Тодруулга 4.13-аас үзнэ үү.

22. Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө (үргэжлэл)

Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийн үндсэн ангиллууд дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө:		
Санхүүгийн бус хөрөнгө:		
Оффис ба худалдааны талбай	38,635,433	5,985,718
Орон сууц	11,479,720	5,325,228
Барилга байгууламж	1,083,642	1,083,642
Тоног төхөөрөмж	1,196,903	-
Бусад	160,719	-
Санхүүгийн хөрөнгө:		
Хөрөнгийн үнэт цаас	-	5,049,835
Нийт борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө	52,556,417	17,444,424

23. Бусад банкуудын байршуулсан хөрөнгө

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Бусад Банкуудын байршуулсан богино хугацаат хөрөнгө	255,246,082	103,933,499
Бусад Банкуудын байршуулсан урт хугацаат хөрөнгө	132,946,151	17,968,518
Нийт бусад банкуудын байршуулсан хөрөнгө	388,192,233	121,902,017

Бусад банк санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж нь дотоодын болон гадаадын банкуудын Банкинд гадаад болон дотоод валютаар үүсгэсэн харилцах данс болон хугацаатай хадгаламжуудаас бүрдэнэ. Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн өсөлтийн дийлэнх хувь хэмжээ нь дотоодын банкны байршуулсан богино болон урт хугацаат хөрөнгөтэй холбоотой.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр богино хугацаат харилцах, хадгаламжид дотоодын болон гадаадын банкуудаас байршуулсан жилийн 1.6% - 14.0% хувийн хүүтэй (2016: 3.0% - 14.5% хувийн хүүтэй) 5-516 хоногийн анхны дуусах хугацаатай (2016: 5-90 хоногийн хугацаатай) харилцах, хадгаламжууд орно.

Бусад банкуудаас байршуулсан хөрөнгийн ангилал бүрийн бодит үнэ цэнийн задаргааг Тодруулга 41-с үзнэ үү. Тодруулга 37-д валютын, хүүний болон төлөгдөх хугацааны шинжилгээг харуулсан.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

24. Харилцагчийн харилцах, хадгаламж

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Төрийн болон хувьцаат компани	270,681,877	185,378,977	270,681,877	185,378,977
- Харилцах данс	207,265,363	109,749,345	207,265,363	109,749,345
- Хугацаагүй хадгаламж	45,518,223	58,278,383	45,518,223	58,278,383
- Хугацаатай хадгаламж	17,898,291	17,351,249	17,898,291	17,351,249
Аж ахуйн нэгж	910,470,692	733,633,909	910,722,982	733,253,306
- Харилцах данс	637,255,237	531,452,603	637,507,527	531,072,000
- Хугацаагүй хадгаламж	50,754,191	60,294,309	50,754,191	60,294,309
- Хугацаатай хадгаламж	222,461,264	141,886,997	222,461,264	141,886,997
Хувь хүмүүс	2,234,190,600	1,852,067,325	2,233,766,425	1,851,900,020
- Харилцах данс	154,058,148	114,728,969	153,633,973	114,561,664
- Хугацаагүй хадгаламж	417,543,390	407,064,810	417,543,390	407,064,810
- Хугацаатай хадгаламж	1,662,589,062	1,330,273,546	1,662,589,062	1,330,273,546
Бусад	38,748,463	32,795,258	38,748,463	32,795,257
- Харилцах данс	26,601,431	19,870,884	26,601,431	19,870,884
- Хугацаагүй хадгаламж	445,708	920,243	445,708	920,243
- Хугацаатай хадгаламж	11,701,324	12,004,131	11,701,324	12,004,130
Нийт харилцагчийн харилцах, хадгаламж	3,454,091,632	2,803,875,469	3,453,919,747	2,803,327,560

Монгол Улсын Иргэний хуулийн дагуу Банк нь харилцах, хадгаламж эзэмшигч иргэдэд хадгалуулагчийн мөнгийг шаардсан үед нь эргүүлэн төлөх үүрэг хүлээсэн байдаг. Хэрэв хугацаатай хадгаламжийг хугацааны өмнө буцаан татсан тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол Банк хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгийн түвшнээр тооцож олгоно.

Одоогийн байдлаар удирдлага харилцагчдын харилцах, хадгаламжийг эдийн засгийн салбарын төвлөрөлтөөр нь хянадаггүй. Иймээс үүнтэй холбоотой мэдээллийг эдгээр санхүүгийн тайлангуудад тусгаагүй. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 30 том харилцагчаас байршуулсан хөрөнгийн нийт дүн 818,650,820 мянган төгрөг (2016 оны 12 дугаар сарын 31: 724,652,186 мянган төгрөг) бөгөөд нийт харилцах хадгаламжийн 24 хувь (2016 оны 12 дугаар сарын 31: 26 хувь)-ийг бүрдүүлж байсан.

Охин компаниас байршуулсан 219,710 мянган төгрөг (2016: 1,231,005 мянган төгрөг) нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд устгагдсан.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр эх үүсвэртэй Банкны баталгааны барьцаанд 8,632,902 мянган төгрөгийн (2016 оны 12 дугаар сарын 31: 7,391,954 мянган төгрөг) харилцагчдаас байршуулсан байсан.

25. Зээлийн бусад эх үүсвэр

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
(А) Төслийн зээлийн эх үүсвэрүүд		
Төслийн зээлийн эх үүсвэр /Төгрөг/	365,213,958	593,876,110
Төслийн зээлийн эх үүсвэр /Доллар/	549,730	921,098
Төслийн зээлийн эх үүсвэр /Евро/	749,063	1,043,461
Нийт төслийн зээлийн эх үүсвэр	366,512,751	595,840,669
(Б) Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр		
Гадаадын Банкаас авсан эх үүсвэр /Доллар/	260,536,421	497,834,077
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Доллар/	104,241,184	89,470,981
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Евро/	15,532,154	4,208,098
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Юань/	10,918,980	5,671,627
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /фунт стирлинг/	155,833	143,302
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Иен/	-	2,701,243
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр	391,384,572	600,029,328
Нийт (А+Б)	757,897,323	1,195,869,997

(А) Төслийн зээлийн эх үүсвэрүүд

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр		
Орон сууцны зээлийн эх үүсвэр	247,279,456	232,770,498
КФВ Банкны төслийн эх үүсвэр	3,741,133	4,580,317
Бусад төслийн эх үүсвэр	581,000	3,111,900
Эрчимжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрийг дэмжих, зоорь агуулахыг нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр	579	5,338,587
Монгол Улсын Хөгжлийн Банкны төслүүд		
ҮХААЯм-арьс шир боловсруулах төслийн эх үүсвэр	15,751,313	21,274,202
Ази-Европын уулзалтанд зориулсан эх үүсвэр	15,242,618	21,422,706
Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр	15,043,458	23,372,257
Бусад төслийн эх үүсвэрүүд	4,428,414	7,839,890
Мах боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн эх үүсвэр	4,256,210	4,506,575
Хөдөө аж ахуй 2016 програм	2,160,888	4,576,397
Ноолууран бүтээгдэхүүний технологийг шинэчлэх төсөл	-	98,354,244
Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	-	48,022,000
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төслийн эх үүсвэр	-	41,133,334
Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл	-	25,926,550
Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	-	3,610,600
Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл		
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	15,654,490	12,001,016
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах төслийн эх үүсвэр	194,596	456,956
Хувийн хэвшилийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр-2 /төгрөг, доллар/	15,824	126,106
Бусад Засгийн газрын төслүүд		
Хөдөлмөр эрхлэгчидийг дэмжих төслийн эх үүсвэр	26,140,600	-
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	12,526,518	14,521,244
Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	1,987,754	1,000,000
Хөдөө Аж Ахуйн Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	1,152,766	1,090,321
Бусад төслийн эх үүсвэр	355,134	460,270
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах төслийн эх үүсвэр	-	18,687,810
Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сангийн эх үүсвэр	-	1,136,070
Орон сууцны санхүүжилтийн төслийн эх үүсвэр	-	485,084
40,000 айлын орон сууц хөтөлбөрийн эх үүсвэр	-	35,735
Нийт төслийн эх үүсвэр	366,512,751	595,840,669

Монгол Улсын Засгийн газар, Төв Банк болон гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэрийн гол нөхцөлүүдийг дор дурьдав:

Тодруулга 3-д үзүүлсний дагуу эдгээр зээлийн эх үүсвэрийн дийлэнх нь Монгол Улсын Засгийн Газрын эсвэл зээл олгогчийн тодорхойлсон тусгай зориулалттай (хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг зорилтод харилцагчдад олгох) зээлүүд байдаг. Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүний хувь нь бага буюу Банк нь өөр зээлд эгчээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг. Эдгээр зээлсэн бусад эх үүсвэрүүдийн ихэнх нь жилийн 0.9-өөс 6 хүртэлх хувийн хүүтэй, харин эдгээр эх үүсвэрээс олгож буй зээлүүдийн ихэнх нь жилийн 3.8-аас 9 хүртэлх хүүтэй байдаг.

Удирдлагын зүгээс эдгээр зээлсэн эх үүсвэрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзлыг хүлээн зөвшөөрөх эсэхийг бодож үзсэн ба тусгай зах зээлийн шинжийг хангаж байгаа учраас эдгээр эх үүсвэр болон харилцагчид олгосон зээлээс ямар нэгэн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз гарз бүртгэгдэхгүй гэж үзсэн. Удирдлагын үнэлэмжийн талаар тодруулга 3-аас үзнэ үү.

Томоохон төсөл хөтөлбөрүүдэд Монгол улсын засгийн газраас Монгол улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий төсөл хөтөлбөрүүд болон салбаруудад (эдийн засгийг тэлэх) зориулсан Монгол Улсын хөгжлийн Банкны санхүүжилтууд багтана. Эдгээр хөтөлбөрүүдийг дор товчхон дурьдвал:

Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан санамж бичигт Монгол улсын засгийн газар болон Монголбанк 2012 оны 10 дугаар сарын 22-нд гарын үсэг зурсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Банк нь 2012 оны 12 дугаар сарын 10-нд Түлшний үнийг тогтворжуулах, 2012 оны 12 дугаар сарын 24-нд хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, 2013 оны 05 дугаар сарын 07-нд Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах тухай гэрээг Монголбанкт тус тус байгуулав. Түлшний үнийг тогтворжуулах болон хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зээлийн хүү жилийн 0.89 хувь бөгөөд Банк хөтөлбөрт хамрагдсан талуудад зээлийн эх үүсвэрийг жилийн 3.8 хувиар дамжуулан олгох юм. Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах зээлийн хүү нь жилийн 2.5-4 хувь бөгөөд Банк хөтөлбөрт хамрагдсан талуудад жилийн 5.5-7 хувийн хүүтэйгээр дамжуулан зээлдүүлнэ. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Банк эх үүсвэрээ заасан хугацаанд Монголбанкинд төлж чадахгүй бол Монголбанк өөрт байршиж буй Банкны данснаас шууд суутгах эрхтэй. 2016 онд Стратегийн импортын санхүүжилтийн схем (СИСС), Хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (ХБҮТ) хөтөлбөрүүд гэрээний дагуу хэрэгжиж дууссан. Банк нь эдгээр хөтөлбөрийн хүрээнд үлдсэн бүх төлбөрийг төлж барагдуулсан байна.

Орон сууцны зээлийг санхүүжүүлэх засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд Банк 2016, 2015 болон 2014 онд 4%-ийн хүүтэй эх үүсвэрийг Монголбанкнаас хүлээн авсан. Энэ хөтөлбөрт тусгай шаардлага хангасан (80 квадрат метрээс бага хэмжээтэй байр, худалдан авах үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх урьдчилгаа, тухайн Банк болон бусад Банкн дахь зээлийн түүх сайн гэх мэт) шинэ болон хуучин олгогдсон зээлүүд хамрагдах боломжтой. Ийнхүү Банк нь зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан харилцагч нарт 8 хувийн хөнгөлөлттэй зээлийг олгох боломжтой болсон ба энэхүү хүүний түвшнийг Монголбанкнаас тогтоож өгсөн тул олгож буй зээлийн хүүг Банк тогтоох эрхгүй гэсэн үг. Хөтөлбөрийн дагуу олгогдох зээлийн саналыг болон 8 хувиас доош олгосон дахин санхүүжилтийг Банкнаас хэлэлцэж батлах ба эрсдлийг мөн үүрэх юм.

Банк Монгол Улсын Хөгжлийн Банкнаас (МУХБ) хэрэгжүүлж буй Засгийн газраас санхүүжүүлж байгаа хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөтөлбөрт оролцож байгаа. 2013 оны 08 дугаар сарын 15-нд хүлэмжийн аж ахуйн, сүү сүүн бүтээгдэхүүний, оёдлын, ноолууран бүтээгдэхүүн болон ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг дунд бизнесийг санхүүжүүлэх зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк нь МУХБ-тай хамт гэрээнд гарын үсэг зурсан. Энэ гэрээний дагуу Банк жилийн 5.13-аас 5.7 хүртэл хувийн хүүтэй эх үүсвэр авч Монгол улсын Хөгжлийн Банкны гэрээнд заасан жилийн 8% хувийн хүүтэй зээлийг харилцагчдад олгосон. Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг.

2014 оны 7 дугаар сараас хойш Банк нь Монгол Улсын Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” зорилготой засгийн газрын өөр нэг төсөлд оролцож байна. Энэхүү хөтөлбөрийн нөхцлийн дагуу Банк нь уг эх үүсвэрийг МУХБ-наас жилийн 5 хувиар авж, харилцагчдад жилийн 7 хувиар олгодог. Бүх зээлдэгчдийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас батал ба Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг.

Түүнчлэн Банк Монгол улсын Хөгжлийн Банк болон арилжааны Банкуудаар дамжуулан “Монгол улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой 888 хөтөлбөр”-ийг санхүүжүүлэх Засгийн газрын төсөлд оролцож байгаа. Энэ гэрээний дагуу Банк нь 5 жилийн хугацаатай жилийн 3-аас 5 хүртэлх хувийн хүүтэй эх үүсвэр авч жилийн 7-оос 9 хувийн таатай хүүтэйгээр зээл олгож байна. Банк тогтоосон босго түвшинд зээлийн хүүг тодорхойлох эрхтэй бөгөөд холбогдох зээлийн эрсдлийг хариуцна.

Банк 2015 онд Засгийн газрын Монгол Улсын Хөгжлийн Банкаар дамжуулан хэрэгжүүлж буй ноолуурын салбарыг санхүүжүүлэх хөтөлбөрт хамтран ажилласан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк 3 хүртэлх жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эх үүсвэрийг авч, зорилтод харилцагчдад 9 хувийн хүүтэйгээр зээл олгох эрхтэй.

Банк 2016 онд Монгол Улсын Хөгжлийн Банкны санхүүжилтээр Ази-Европын 11 дэх уулзалтын төлөөлөгчдийг байршуулах зочид буудлыг санхүүжүүлэх хөтөлбөрт хамрагдсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк гэрээний дагуу жилийн 4.5 хувийн хүүтэй эх үүсвэр авч 13 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг шаардлага хангасан зочид буудлуудад олгосон. Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг.

25. Зээлийн бусад эх үүсвэр (үргэлжлэл)

(А) Төслийн зээлийн эх үүсвэрүүд (үргэлжлэл)

Банк 2017 оны 2 дугаар сарын 10-наас Засгийн газраас хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэгчидийг дэмжих төслийн хөтөлбөрт оролцож эхэлсэн. Төслийн хүрээнд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес эрхлэгчид болон хувь хүмүүст жижиг болон дунд хэмжээний зээлийг 2 жилийн хугацаатай, 3 хувийн хүүтэй олгох эрхтэй санхүүжилтийг Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас хүлээн авсан. Банк нь энэхүү зээлийн эрсдэлийг үүрдэг.

Мөн засгийн газрын хэрэгжүүлж буй Монгол улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк Монгол улсын Хөгжлийн Банктай жижиг дунд бизнесийн төслүүдийг дэмжих гэрээнд гарын үсэг зурсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк жилийн 6 хувийн хүүтэй, 2019 оны 03 дугаар сарын 05 хүртэлх хугацаатай эх үүсвэрийг авсан. Банк зорилтод харилцагчдад зээл олгохдоо жилийн 9 хувь хүртэлх хүүг тогтоох эрхтэй.

2017 оны 12 дугаар 31 –ны байдлаар Банк гадны эх үүсвэрийн санхүүжилтийн гэрээний дагуу биелүүлэх шаардлагатай үүргээс нээлттэй зээлийн эрсдэлийн харьцаа, чанаргүй зээлийн харьцааны гэсэн хоёр үүргийн зөрчилтэй байсан. Эдгээр зөрчилүүд нь Уорлд Бизнес Капитал - ын 1,187,406 мянган төгрөг болон Экспорт Дэвелопмент Канада-ийн 17,560,810 мянган төгрөгийн эх үүсвэртэй тус тус холбоотой. Тиймээс эдгээр зээлдэгчээс үүргээс чөлөөлөх бичиг авах хүсэлт гаргасан боловч 2017 оны 12 дугаар сарын 31 –ны байдлаар хариу ирээгүй байна. СТОУС –н дагуу Банкны удирдлагын зүгээс эдгээр зээлийг “Хугацаагүй болон 1-ээс бага сар” ангилалд ангилсан. Мөн удирдлагын зүгээс үүргээс чөлөөлөх бичиг удахгүй ирнэ гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд ойрын хугацаанд зөвшөөрөгдөх боломжтой хэмээн үзсэний үндсэн дээр дуусах хугацааны талаар нэмэлт мэдээлэлийг тусгасан. Тодруулга 37-гоос үзнэ үү. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөөгүй байсан.

Категори	Зээл олгогч	Төслийн нэр	Валют	Олгосон огноо	Дуусах огноо	2017.12.31 – нээрх зээлийн дүн /тухайн валютаар/	2017.12.31 – нээрх зээлийн дүн /төгрөгөөр/
Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр	Монголбанк	КФВ Банкны төслийн эх үүсвэр	Евро	12/11/2012	12/25/2020	258	748,881
	Монголбанк	Орон сууцны зээлийн эх үүсвэр	Төгрөг	5/30/2017	9/30/2019	28,026,480	28,026,480
	Монголбанк	Бусад төслийн эх үүсвэр	Төгрөг	5/7/2001	5/7/2018	581,000	581,000
	Монголбанк	КФВ Банкны төслийн эх үүсвэр	Төгрөг	5/16/2013	6/25/2021	2,984,980	2,984,980
	Монголбанк	Орон сууцны зээлийн эх үүсвэр	Төгрөг	6/14/2013	9/30/2019	219,104,309	219,104,309
Монгол Улсын Хөгжлийн Банкны төслүүд	Монгол Улсын Хөгжлийн Банк	Ази-Европын уулзалтанд зориулсан эх үүсвэр	Төгрөг	3/11/2016	12/21/2018	15,235,000	15,235,000
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Хөдөө аж ахуй 2016 програм	Төгрөг	4/14/2016	6/29/2018	2,143,206	2,143,206
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Мах боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	3/25/2016	2/28/2020	4,250,000	4,250,000
	Монгол Улсын Хөгжлийн Банк	ҮХААЯам-арьс шир боловсруулах төслийн эх үүсвэр	Төгрөг	8/22/2014	7/27/2021	15,740,382	15,740,382
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр (2 тэрбум – с бага)	Төгрөг	9/1/2014	12/30/2019	176,693	176,693
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр (2 тэрбум – с их)	Төгрөг	8/28/2014	1/29/2020	14,857,819	14,857,819
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Экспортыг дэмжих, импортыг орлох төслийн эх үүсвэр (300 тэрбум хүртэлх)	Төгрөг	9/28/2015	11/27/2020	4,425,464	4,425,464
Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл	ЖАЙКА	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	06/12/2009	12/31/2017	15,489,028	15,489,028
	ЖАЙКА	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	USD	09/29/2006	12/31/2019	80	194,167
	Дэлхийн Банк	Хувийн хэвшилийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр-2 /төгрөг/	MNT	10/18/2007	12/20/2017	11,536	11,536
Бусад Засгийн газрын төслүүд	Засгийн газар	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	07/10/2012	12/31/2017	5,516,365	5,516,365
	Засгийн газар	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	06/12/2015	03/05/2019	7,097,032	7,097,032
	Засгийн газар	Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	MNT	11/30/2016	11/30/2026	1,987,754	1,987,754
	Засгийн газар	Хөдөө Аж Ахуйн Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	MNT	02/10/2011	12/13/2019	1,149,202	1,149,202
	Засгийн газар	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	MNT	02/08/2017	8/1/2024	26,140,600	26,140,600
	Засгийн газар	Бусад төслийн эх үүсвэр (гадаадын банкнаас авсан сургалтын зээл)	USD	11/12/2009	05/01/2027	144	350,169

Голомт Банк Групп

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2017 оны 12 дугаар сарын 31

25. Зээлийн бусад эх үүсвэр (үргэлжлэл)

(Б) Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр

Гадаадын банк авсан авсан 247,279,457 мянган төгрөгийн эх үүсвэр нь гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас авсан 2016 оны 7 дугаар сарын 15 –нд 24 сарын хугацаатай авсан 100,000 мянган ам доллар болон 2017 оны 9 дүгээр сарын 29- нд 97 сарын хугацаатай авсан 7,500 мянган ам долларын зээлийг илэрхийлнэ. Уг зээлийн 100,000 мянган ам доллар нь Банкны тухайн банкин дахь харилцах дансаар баталгаажсан. (Дэлгэрэнгүйг тодруулга 11-с үзнэ үү.)

Банк нь өөрийн харилцагчдын худалдааны зээлийг санхүүжүүлэх зорилгоор гадаадын Банк болон санхүүгийн байгууллагаас худалдааны зээлийн эрх авсан. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 127,290,678 мянган төгрөгийн (2016 оны 12 дугаар сарын 31: 102,195,250 мянган төгрөг) зээлийн шугамыг ашиглаж мөн тэр хэмжээний зээлийг харилцагчдын импортын үйл ажиллагаанд зориулан олгосон байна. Ийм төрлийн эх үүсвэрийн хугацаа нь 3 хүртэлх жил байдаг бөгөөд харилцагчдын мөнгөн урсгал хийгээд гадаадын Банк санхүүгийн байгууллагад хийх эргэн төлөлтийн хугацаа нь таарч байна. Харилцагч зээлээ төлж чадахгүй тохиолдолд Банк зээлийн эрсдлийг хариуцдаг. Худалдааны эх үүсвэрийн өсөлт нь бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас болон гадаадын банкнаас шинээр доллар болон евро-оор авсан санхүүжилттэй холбоотой.

Бусад зээлийн эх үүсвэрийн задаргааг Тодруулга 41-с харна уу. Бусад зээлийн эх үүсвэрийн валютын, зээлийн хүүний болон эргэн төлөгдөх хугацааны шинжилгээг Тодруулга 37-с харна уу.

Эдгээр гадны банк болон санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэрүүд нь гэрээний дагуу хүлээсэн санхүүгийн үүрэгтэй ба 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөөгүй байсан.

26. РЕПО хэлцэл

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан РЕПО хэлцэлд нь 7.5-11 хувийн хүүтэй (2016: 7.5 -17 хувийн хүүтэй), 7-941 хоногийн хугацаатай (2016: 7-941 хоногийн хугацаатай) РЕПО хэлцлүүд орно. Эдгээр РЕПО хэлцлүүд нь Монголбанкны үнэт цаасаар болон Өрийн бичгээр бүрэн баталгаажсан. Дэлгэрэнгүйг тодруулга 13, 15 болон 39-аас үзнэ үү.

27. Бусад өр төлбөр

Бусад өр төлбөрийг дэлгэрэнгүй байдлаар дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Бусад санхүүгийн өр төлбөр	48,630,469	31,383,555	48,630,446	31,353,878
Гүйлгээний өр төлбөр	28,354,420	18,336,020	28,354,420	18,336,020
Буцаах нөхцөлтэй МИК-д худалдсан зээлтэй холбоотой өр төлбөр	8,327,985	5,539,233	8,327,985	5,539,233
Дансны өглөг	4,796,355	1,315,093	4,796,332	1,315,093
Бусад	7,151,709	6,193,209	7,151,709	6,163,532
Бусад санхүүгийн бус өр төлбөр	3,763,827	2,710,213	3,610,230	2,701,720
Ажилтнуудад өгөх өглөг	1,721,668	1,527,632	1,675,272	1,527,450
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	2,042,159	1,182,581	1,934,958	1,174,270
Нийт бусад өр төлбөр	52,394,296	34,093,768	52,240,676	34,055,598

Гүйлгээтэй холбоотой төлбөрийн нь 2017 оны 12 дугаар сарын сүүлчийн өдрүүдэд харилцагчийн хүсэлтийн дагуу хийгдсэн шилжүүлгийн гүйлгээ ба тэдгээр нь 2018 оны 01 дүгээр сарын эхээр бусад Банкуудад шилжүүлэгдэнэ. Иймээс харилцагчийн данснаас гүйлгээний дүн нь хасагдаж бусад өр төлбөрийн хэсэг болох "Гүйлгээний төлбөр" тусгай дансанд 2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар орсон ба 2018 оны 01 дүгээр сард энэхүү гүйлгээ нь Банк хоорондын тооцоогоор хийгдэж дууссан.

2017 онд Банк 2 удаагийн 8 хувийн орон сууцны зээлийг буцаах нөхцөлтэй худалдах МИК-ийн мөнгөжүүлэх гүйлгээнд оролцсон. Банк 2017 онд 4,990,024 мянган төгрөгийн болон 4,261,089 мянган төгрөгийн 8 хувийн орон сууцны зээлийн багцаа зарж 15 хувийн хүүтэй эх үүсвэр авсан. Эдгээр МИК-д худалдсан 8 хувийн орон сууцны зээлтэй холбоотой эрсдэл өгөөж нь Банкинд үлдсэн. Иймээс эдгээр хөрөнгө нь данснаас хасах шаардлагыг хангаагүй ба МИК-ээс авсан эх үүсвэрийг санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бусад өр төлбөрт байгаа уг өр төлбөр нь холбогдох зээлийн эргэн төлөлтөөр буурсан байна.

Бусад санхүүгийн өр төлбөрийн дийлэнх нь тайлант хугацаанаас хойш арван хоёр сарын дотор төлөгддөг ба бүх санхүүгийн бус өр төлбөр нь шинж чанарын хувьд богино хугацаатай байдаг.

28. Хоёрдогч өглөг

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
Голомт Файнэншил Группээс авсан хоёрдогч өглөг	97,042,814	87,733,803
Нийт	97,042,814	87,733,803

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

2017 оны 12 дугаар сарын 31-нээрх хоёрдогч өглөг:

Мянган төгрөгөөр	Дуусах огноо	Валют	Хүү	Бодит дүн /тухайн валютаар
Голомт Файнэншил Групп (I)	31/12/2023	USD	8.0%	10,000,000
Голомт Файнэншил Групп (II)	08/12/2024	USD	8.0%	25,000,000
Голомт Файнэншил Групп (III)	27/07/2023	MNT	13.5%	12,000,000

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (I)

2007 онд Голомт Банк нь Кредит Свисс-ийн Сингапур улс дахь салбараас 5 жилийн хугацаатай, 10 сая ам.долларын хоёрдогч өглөгийг авсан. Зээлийн хугацаа 2012 оны 12 дугаар сарын 19-ны өдөр дууссан бөгөөд энэ өдрөөр зээл нь хувьцаанд хөрвөөгүй эсвэл эргэн төлөгдөөгүй байсан.

2013 оны 12 дугаар сарын 31-ны өдөр Кредит Свисс-н хоёрдогч өглөгийг Бодь Интернэшнл ХХК-д шилжүүлэх гэрээний нэмэлт өөрчлөлт дээр компанийн гол хувьцаа эзэмшигч болох Бодь Интернэшнл ХХК болон Голомт Банк ХХК гарын үсэг зурсан.

Шилжүүлэх гэрчилгээн дээр 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Голомт Банк, Бодь Интернэшнл ХХК, Кредит Свисс Ай Жи буюу Сингапур улс дахь салбар гарын үсэг зурснаар Бодь Интернэшнл ХХК буюу Банкны гол хувьцаа эзэмшигч нь 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Кредит Свисс-с авсан хоёрдогч өглөгийг худалдаж авсан.

Кредит Свисс-н хоёрдогч өглөгийн зээлийн гэрээнд зээлдэгч нь хүссэн үедээ урьдчилан тохирсон худалдаж авах үнээр зээлийг энгийн хувьцаа руу хөрвүүлж болох нөхцөл болон санхүүгийн заавал биелүүлэх гэрээний нөхцөлүүдтэй байсан ба Бодь Интернэшнл ХХК-тай хийсэн хоёрдогч өглөгийн гэрээний хувьд энгийн хувьцаа руу хөрвүүлэх болон гэрээний заавал биелүүлэх нөхцөлүүдийг гэрээний өөрчлөлтөөр хассан.

Гэрээний гол нөхцөлүүд:

- (А) Зээлийн хүү нь жилийн 8%.
- (Б) Зээл нь 2023 оны 12 дугаар сарын өдөр үндсэн дүн болон хуримтлагдсан хүүний хамт төлөгдөнө

2014 оны 07 дугаар сарын 07-нд Банкны эзэмшлийг Голомт Файнэншил Групп ХХК –руу шилжүүлсний дагуу уг хоёрдогч өглөгийг мөн Банкны шинэ гол хувьцаа эзэмшигч болох Голомт Файнэншил Групп ХХК –руу шилжүүлсэн. 2016 оны 9 сарын 30-ны өдөр Голомт Файнэншил Групп ХХК болон Голомт банкны хооронд байгуулагдсан гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу хоёрдогч өглөгийн дуусгавар хугацаа болон хүүний хувийг сунгасан болно. Хоёрдогч өглөгийн хүүний хувь 6 хувиас 8 хувь болж, дуусгавар хугацаа нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31 ны хүртэл сунгагдсан болно.

28. Хоёрдогч өглөг (үргэлжлэл)

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (II)

2010 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Банк нь Абу Дави Инвестментс Консулын 100% эзэмшлийн Стэнхөп Инвестментсээс 5 жилийн хугацаатай 25 сая ам. долларын хөрвөх зээлийг дараах нөхцөлтэйгээр авсан. Үүнд:

- Зээлийн хүү нь 3 сарын ЛИБОР дээр 4.5%-ийг нэмсэнтэй тэнцэх хүүтэй байх ба улирал бүр төлөгдөнө.
- Стэнхөп Инвестментс нь зээлийн гэрээний хугацаанд хүссэн үедээ уг зээлийг урьдчилан тохирсон худалдах, худалдан авах үнээр Банкны энгийн хувьцааруу хөрвүүлэх эрхтэй.
- Хэрэв гэрээнд тусгасан санхүүгийн болон санхүүгийн бус шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд Стэнхөп Инвестментс нь Банкаас зээлийг эргүүлэн төлөхийг шаардах эрхтэй.

2014 оны 04 дүгээр сарын 30-нд шилжүүлэх гэрчилгээн дээр Бодь Интернэшнл ХХК, Голомт Банк ХХК болон Стэнхөп Инвестментс гарын үсэг зурснаар Банкны гол хувьцаа эзэмшигч болох Бодь Интернэшнл ХХК нь уг зээлийг Стэнхөп Инвестментсээс худалдаж авсан. Бодь Интернэшнл ХХК-тай хийсэн хоёрдогч өглөгийн гэрээний хувьд энгийн хувьцааруу хөрвүүлэх болон биелүүлэх ёстой шаардлагуудыг гэрээний өөрчлөлтөөр хассан. 2014 оны 07 дугаар сарын 07-нд Банкны эзэмшлийг Голомт Файнэншил Групп ХХК-руу шилжүүлсний дагуу уг хоёрдогч өглөгийг мөн Банкны шинэ гол хувьцаа эзэмшигч болох Голомт Файнэншил Групп ХХК-руу шилжүүлсэн.

Уг хоёрдогч өглөгийн хугацаа 2015 оны 06 дугаар сарын 08-нд дууссан ба Банк болон Голомт Файнэншил Групп гэрээний өөрчлөлтөд гарын үсэг зурснаар уг зээлийн дуусах хугацааг 2020 оны 12 дугаар сарын 08 болгож сунгасан. 2016 оны 9 сарын 30-ны өдөр Голомт Файнэншил Групп ХХК болон Голомт банкны хооронд байгуулагдсан гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу хоёрдогч өглөгийн дуусгавар хугацааг сунгаж, хүүний хувийг өөрчилсөн болно. Хоёрдогч өглөгийн хүүний хувь 5.1 хувиас 8 хувь болж, дуусгавар хугацаа нь 2020 оны 12 дугаар сарын 08-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 08-ний хүртэл сунгагдсан болно.

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (III)

2017 онд Банк нь Голомт Файнэншил Групп ХХК –ээс 6 жилийн хугацаатай 12,000,000 мянган төгрөгийн хоёрдогч өглөгийг 13.5 хувийн хүүтэй, хугацааны эцэст энгийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэйгээр авсан. Энэхүү шинэ хоёрдогч өглөгт гэрээний дагуу биелүүлэх шаардлагатай хүлээсэн санхүүгийн үүрэг байгаа ба 2017 оны 12 дугаар сарын 31 – ны байдлаар биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөөгүй байсан.

2017 оны 12 дугаар сарын 31 ба 2016 оны 12 дугаар сарын 31-нээр бусад хоёрдогч өглөгүүдэд биелүүлэх шаардлагатай санхүүгийн болон санхүүгийн бус хүлээсэн үүрэг байхгүй. Холбоотой талуудын ажил үйлчилгээний мэдээллийг тодруулга 43-аас үзнэ үү.

29. Хувьцаат капитал

Хувьцааны тоо ширхэгээс бусад дүн нь Мянган төгрөгөөр	Нийт гаргасан хувьцаа	Энгийн хувьцаа	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Давуу эрхтэй хувьцаа	Нийт
2016 оны 01 сарын 01-нээр	26,367,593	26,367,593	46,583,557	25,778,900	98,730,050
2016 оны 12 сарын 31-нээр	26,367,593	26,367,593	46,583,557	25,778,900	98,730,050
2017 оны 12 сарын 31-нээр	26,367,593	26,367,593	46,583,557	25,778,900	98,730,050

Банкны гаргасан хувьцаат капиталын нэрлэсэн үнээр бүртгэгдсэн дүн нь 26,367,593 мянган төгрөг (2016: 26,367,593 мянган төгрөг) байсан.

Нэмэгдэж төлөгдсөн хувьцаа нь шинээр гаргасан хувьцааг борлуулахад нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн төлбөр юм.

Энгийн хувьцаа

2017 оны 12 дугаар сарын 31 байдлаар Банк нь нийт 26,367,593 ширхэг (2016 оны 12 дугаар сарын 31: 26,367,593) нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй (2016: 1000 төгрөг) энгийн хувьцаа гаргасан байсан. Гаргасан бүх энгийн хувьцаа нь бүрэн төлөгдсөн байсан.

2017 онд нэг бүр нь 1,000 нэрлэсэн үнэтэй 1,300,000 бүрэн төлөгдсөн хувьцааг Трафикура Бэхээр Би. ви –ээс Голомт Инвестмент ХХК –рүү шилжүүлсэн.

2017 оны 12 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх хувьцаа эзэмшигчдийн хувийг доорх байдлаар харуулав:

Хувьцаа эзэмшигч	2017	2016
	Хувиар	Хувиар
Голомт Файнэншил Групп ХХК	83.76%	83.76%
СВИС МО Инвестмент Эй жи	9.98%	9.98%
Трафигура Бэхээр Би.ви	-	4.93%
Голомт Инвестмэнт ХХК	4.93%	-
Ажилчдын хувьцаа	1.33%	1.33%
Нийт	100%	100%

Давуу эрхтэй хувьцаа

2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн давуу эрхийн хувьцаа гаргах хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн дагуу 2013 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Голомт Банк болон Ноён Зоригт (Ноён Баясгалангийн бизнес хамтрагч) нарын хооронд давуу эрхтэй хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан

Гэрээний дагуу Банкны давуу эрхтэй хувьцаанд олгож буй нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 15,000,000 ам.доллар бөгөөд хоёр үе шаттай хэсэгчилсэн төлбөр байна. (2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 10 сая ам.доллар мөн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 5 сая ам.доллар).

2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар давуу эрхтэй хувьцааны нийт дүн 15,000,000 ам.доллар буюу 25,788,900 мянган төгрөгтэй тэнцэх 25,788,900 ширхэг давуу эрхтэй хувьцаа байна.

30. Хүүгийн орлого ба зардал

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Хүүгийн орлого				
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	293,489,976	261,336,134	293,489,976	261,336,134
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт	46,040,736	20,684,079	46,040,736	20,684,079
Богино хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас	41,123,291	23,621,571	41,123,291	23,621,571
Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт	12,892,817	15,870,152	12,619,867	15,662,474
Бэлэн мөнгө болон Төв Банкинд байршуулсан мөнгө	12,417,998	9,387,860	12,417,998	9,387,860
Бусад Банкинд байршуулсан хөрөнгө	3,156,025	867,077	3,155,790	867,077
Урвуу репо хэлцэл	372,197	340,315	372,197	340,315
Нийт хүүгийн орлого	409,493,040	332,107,188	409,219,855	331,899,510
Хүүний зардал				
Харилцагчдын харилцах, хадгаламж	(230,559,406)	(193,233,346)	(230,561,263)	(193,237,793)
Зээлийн бусад эх үүсвэр	(36,996,420)	(38,531,051)	(36,996,420)	(38,531,051)
Хоёрдогч өглөг	(7,626,284)	(6,085,952)	(7,626,284)	(6,085,952)
Бусад Банкуудын байршуулсан хөрөнгө	(8,568,659)	(5,148,134)	(8,568,659)	(5,148,134)
Репо хэлцэл	(3,476,881)	(3,412,605)	(3,476,881)	(3,412,605)
Нийт хүүний зардал	(287,227,650)	(246,411,088)	(287,229,507)	(246,415,535)
Цэвэр хүүний орлого	122,265,390	85,696,100	121,990,348	85,483,975

Голомт Банк Групп

30. Хүүгийн орлого ба зардал (үргэлжлэл)

Харилцагчид олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлогын өсөлт нь 2017 онд харилцагчид олгосон зээлийн өсөлттэй холбоотой. Түүнчлэн, Мөнгө болон Төв Банкинд байршуулсан хөрөнгийн хүүний орлого 11,403,260 (2016: 9,149,482 мянган төгрөг) мянган төгрөг нь Монголбанкны тушаалын дагуу бүх банкуудад олгосон Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөцийг 2017 онд хангаж байсантай холбоотой урамшуулал юм.

Харилцагчид олгосон үнэ цэнэ буурсан зээлээс хүлээн зөвшөөрсөн хүүгийн орлого 8.7 тэрбум төгрөг байсан (2016: 10.1 тэрбум төгрөг). Удирдлагын зүгээс эдгээр зээлүүд нь бүрэн төлөгдөх ба үнэ цэнэ нь буурсан зээлүүд нь өндөр дүнтэй барьцаа хөрөнгөтэй гэж үзсэн. Мөн СТОУС-ын дагуу эргэн төлөгдөхгүй гэж үзсэн зээлийн хүүний орлогыг 2017 болон 2016 оны орлого зардалд хүлээн зөвшөөрөөгүй.

31. Хураамж, шимтгэлийн орлого ба зардал

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Хураамж, шимтгэлийн орлого				
Карттай холбоотой шимтгэл хураамж	19,476,085	13,014,091	19,476,085	13,014,092
Гуйвуулгын ба бусад үйлчилгээний хураамж	8,572,030	7,192,124	8,572,030	7,135,876
Дансны үйлчилгээний шимтгэл хураамж	3,887,024	3,370,834	3,888,233	3,367,956
Баталгаа болон бусад бичиг цаасны шимтгэл, хураамж	3,336,650	3,494,876	3,336,650	3,494,876
Брокерийн болон бусад үйлчилгээний хураамж	1,421,753	1,369,102	377,126	969,566
Нийт хураамж, шимтгэлийн орлого	36,693,542	28,441,027	35,650,124	27,982,366
Нийт хураамж, шимтгэлийн зардал				
Картын гүйлгээний зардал	(7,338,953)	(5,753,370)	(7,338,954)	(5,753,370)
Банкны үйлчилгээний зардал	(2,244,096)	(1,686,488)	(1,891,041)	(1,596,299)
Онлайн гүйлгээний зардал	(382,746)	(259,157)	(382,746)	(259,157)
Брокерийн болон бусад үйлчилгээний зардал	(208,391)		(196,044)	-
Нийт хураамж, шимтгэлийн зардал	(10,174,186)	(7,699,015)	(9,808,785)	(7,608,826)
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	26,519,356	20,742,012	25,841,339	20,373,540

Карттай холбоотой шимтгэл хураамжийн орлого болон картын гүйлгээний зардлын өсөлт нь 2017 онд картын бизнесийн өргөжилттэй холбоотой.

32. Үйл ажиллагааны бусад орлого

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Данснаас хасагдсан зээлийн эргэн төлөлт	1,266,457	943,167	1,266,457	943,167
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин хэмжилтын олз	527,707		527,707	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз/(гарз)	13,351	42,174	12,751	42,174
Бусад	(276,131)	411,695	(288,752)	406,382
Нийт үйл ажиллагааны бусад орлого	1,531,384	1,397,036	1,518,163	1,391,723

33. Удирдлага ба үйл ажиллагааны зардал

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Ажилчдын зардал	31,003,901	30,908,674	30,642,006	30,747,704
Удирдлагын зардал	16,140,317	9,659,404	16,039,618	9,615,557
Мэргэжлийн үйлчилгээний зардал	11,402,091	7,560,235	11,397,691	7,555,529
Үндсэн хөрөнгийн элэгдэл	8,775,951	9,669,168	8,762,817	9,661,972
Түрээсийн зардал	5,934,566	5,786,325	5,893,526	5,733,987
Зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээ	3,027,679	2,133,614	3,023,768	2,127,745
Зээлийн цуглуулалтын зардал	1,794,054	1,790,959	1,794,054	1,790,959
Програм болон биет бус хөрөнгийн элэгдэл	1,621,165	2,845,311	1,619,599	2,845,311
Орлогын албан татвараас бусад татварын зардал	1,419,818	1,408,834	1,419,818	1,408,834
Тээврийн зардал	916,014	895,116	914,492	894,489
Томилолтын зардал	842,978	742,586	835,269	721,410
Ашиглалтын зардал	661,618	614,482	660,965	600,641
Хүлээн авалтын зардал	542,240	478,315	539,310	478,315
Сайн дурын болон заавал даатгах даатгалын зардал	426,250	466,151	425,830	466,151
Данснаас хассан үндсэн хөрөнгө	45,225	17,209	45,225	17,209
Хандив	1,000	164,600	1,000	164,600
Бусад	1,595,262	2,427,760	1,568,456	2,420,880
Нийт удирдлагын ба үйл ажиллагааны зардал	86,150,129	77,568,744	85,583,444	77,251,293

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Ажилчдын зардал:				
Цалин хөлс, урамшуулал	27,157,431	26,834,382	26,827,803	26,691,584
Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл	2,847,888	2,880,108	2,815,622	2,864,401
Ажилчдын тэтгэмж	459,188	620,815	459,188	620,815
Ажилчдын сургалт	650,223	419,222	650,223	416,757
Тэтгэвэрийн сан	(110,830)	154,147	(110,830)	154,147
Нийт ажилчдын зардал	31,003,900	30,908,674	30,642,006	30,747,704

34. Орлогын албан татвар

Тухайн жилийн орлого, зарлагад бүртгэсэн орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Тайлант жилийн орлогын албан татвар	6,053,994	-	6,035,112	-
Хойшлогдсон орлогын татвар	(12,965,193)	7,471,460	(12,965,193)	7,472,658
Тайлант жилийн орлогын татварын зардал	(6,911,199)	7,471,460	(6,930,081)	7,472,658

Банк орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон орлогын татварын орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 3 тэрбум (2016: 3 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10 хувийн, 3 тэрбумаас (2016: 3 тэрбум) давсан дүнгээс 25 хувь (2016: 25 хувь)-ийн орлогын албан татвар төлдөг.

34. Орлогын албан татвар (үргэлжлэл)

Тооцоолсон болон бодит татварын зардлын тохируулалтыг доорх хүснэгтэнд харуулав:

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2017	2016	2017	2016
Татварын өмнөх ашиг	(12,238,502)	13,059,208	(12,082,935)	12,746,219
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал (2017: 25%; 2016: 25%)	(3,059,626)	3,264,802	(3,020,733)	3,186,555
Татвар ногдохгүй орлого, татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын татварын нөлөө:				
- Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө	(450,000)	(450,000)	(450,000)	(450,000)
- Татвар ногдох орлогоос чөлөөлөгдөх орлого	(912,990)	(269,435)	(912,990)	(268,373)
- Хасагдахгүй зардал	1,482,350	2,612,450	1,482,350	2,610,943
- Засгийн газрын үнэт цаасны орлого (татвараас чөлөөлөгдөх)	(11,329,720)	(5,408,961)	(11,329,720)	(5,359,677)
- Ирээдүйд шилжүүлэгдэх бүртгээгүй татварын тайлангийн алдагдал	7,301,012	7,753,210	7,301,012	7,753,210
- Бусад	57,773	(30,606)	-	-
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	(6,911,201)	7,471,460	(6,930,081)	7,472,658

2017 онд гарсан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал нь баримтаар нотлогдоогүй хүлээн авалтын зардал, болон сургалтын зардалтай холбоотой. Түүнчлэн, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдөх засгийн газрын үнэт цаасны орлого өссөн нь 2017 онд өмнөх онтой харьцуулахад засгийн газрын үнэт цаасны арилжааны дүн их байсантай холбоотой.

2017 оны 25 хувиар татвар ногдуулдаг түр зөрүүний хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөө:

Мянган төгрөгөөр	2017 оны 01 сарын 01	Ашиг, алдагдалд тусгасан	Эзэмшигчдийн өмчид шууд тусгасан	2017 оны 12 сарын 31
Хасагдах/татвар ногдох түр зөрүүгийн татварын нөлөө				
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа - 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого	(13,323,282)	2,808,295	-	(10,514,987)
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө (Хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлт)	302,601	(401,939)	-	(99,338)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(1,606,796)	-	(11,836,946)	(13,443,742)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт,	(20,290,007)	11,471,642	-	(8,818,365)
Урьдчилсан орлого – зээл олголтын төлбөр	1,291,950	240,930	-	1,532,880
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа - МБ болон СТОУС-ын эрсдлийн сангийн зөрүү	(1,221,508)	7,523,966	-	6,302,458
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт	-	5,039,406	-	5,039,406
Ирээдүйд шилжүүлэгдэх татварын тайлангийн алдагдал	24,511,500	(13,786,123)	-	10,725,377
Бусад	(343,776)	69,016	-	(274,760)
Нийт хойшлогдсон татварын өглөг	(10,679,318)	12,965,193	(11,836,946)	(9,551,071)

2016 оны 25 хувиар татвар ноогдуулдаг түр зөрүүний хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөө:

Мянган төгрөгөөр	2016 оны 01 сарын 01	Ашиг, алдагдалд тусгасан	Эзэмшигчдийн өмчид шууд тусгасан	2016 оны 12 сарын 31
Хасагдах/татвар ногдох түр зөрүүгийн татварын нөлөө				
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа - 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого	(5,143,512)	(8,179,770)	-	(13,323,282)
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө (Хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлт)	1,036,375	(733,774)	-	302,601
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(1,473,130)	-	(133,666)	(1,606,796)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(10,051,754)	(10,238,253)	-	(20,290,007)
Урьдчилсан орлого – зээл олголтын төлбөр	1,045,622	246,328	-	1,291,950
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа - МБ болон СТОУС-ын эрсдлийн сангийн зөрүү	11,495,335	(12,716,843)	-	(1,221,508)
Ирээдүйд шилжүүлэгдэх татварын тайлангийн алдагдал	-	24,511,500	-	24,511,500
Бусад	18,070	(361,846)	-	(343,776)
Нийт хойшлогдсон татварын өглөг	(3,072,994)	(7,472,658)	(133,666)	(10,679,318)

Мянган төгрөгөөр	2017	2016
Ирээдүйд шилжүүлэгдэх татварын тайлангийн алдагдал дуусах хугацаагаар:		
- 2018 оны 12 сарын 31-нээр	10,725,377	24,511,500
Нийт ирээдүйд шилжүүлэгдэх татварын тайлангийн алдагдал	10,725,377	24,511,500

35. Өмчийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хүлээн зөвшөөрсөн бусад дэлгэрэнгүй орлого

Өмчийн бүрэлдэхүүн хэсэг дэх бусад дэлгэрэнгүй орлогын задаргааг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2017 он	2016 он
Өөрчлөлт орсон:		
- Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт (хураан авсан санхүүгийн барьцаа хөрөнгийг оруулаад)	47,347,785	534,662
- Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(5,242,377)	2,738,497
Шууд дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн татварын зардал	(11,836,946)	(295,339)
Бусад дэлгэрэнгүй орлого	30,268,462	2,977,820

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

